



БОАЖЯ -ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ  
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАРТ

**ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК**

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,  
Их Монгол Улсын гудамж,  
Моннис Бьюлдинг, 9-р давхар  
Утас: + (976) 7720-0990  
Email: admin@tkt.mn

2024.03.25 № 24/063  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тайлан хянуулах тухай

Манай компани Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг дэвсгэрт “Гаалийн хяналтын талбай, ажилчдын хотхон, авто бааз” төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 оны 2-р сарын 08-ны өдрийн батлагдсан 2020/Т-180 дугаар бүхий Байгаль орчны нарийвчилсан байдлын үнэлгээнд суурилан боловсруулсан 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот бүхий журмын дагуу боловсруулан хүргүүлж байна.

Иймд 2023 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийг хянан шалгаж, бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Хавсралтаар:

Дорноговь аймгийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг – Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2024 оны 3-р сарын 20-ны өдрийн 2023/19 тоот бүхий “Дүгнэх хуудас болон чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТАХИЛТ  
ХАЙРХАН ТРАНС  
ХХК

ЛАЙ ЖЕНЬБАО



БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ-НЫ  
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГА

Б.БУЯННЭМЭХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



ЛАЙ ЖЭНЬ БАО

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН  
АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ,  
АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/ АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6284655 /

ХЯНАСАН:

БОАЖЯ-НЫ ХБОБЗГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

П. ШИНЭЦЭЦЭГ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



ЛАЙ ЖЭНЬ БАО

Б. ЛХАГВАЖАРГАЛ

2023 ОН

## АГУУЛГА

Зургийн жагсаалт .....	6
Зураг 1. Гаалийн хяналтын талбайн хөрсний мониторингийн цэгийн байршил .....	6
Зураг 2. Асгаралтын сургалт .....	6
Зураг 3. Ханги ажилчдын хотхон – Асгаралтын бүртгэл .....	6
Зураг 4. Гаалийн хяналтын талбай – Асгаралтын бүртгэл .....	6
Зураг 5. Амьтны тооллого судалгаа .....	6
Зураг 6. Гаалийн хяналтын талбайн ургамлын мониторинг .....	6
Зураг 7. Ханги кемпийн ургамлын мониторингийн үр дүн .....	6
Зураг 8. Байгаль орчны зурагт постерууд .....	6
Зураг 9. Гаалийн хяналтын талбайн мод тарилтын ажил .....	6
Зураг 10. Ханги ажилчдын хотхоны талбайн мод тарилтын ажил .....	6
Зураг 11. Ханги ажилчдын хотхоны модны арчилгаа .....	6
Зураг 12. Соёлын өвийг хамгаалах тухай зурагт постер .....	6
Зураг 13. Байгаль орчны дотоод ажлын байрны үзлэг .....	6
Зураг 14. Энгийн хог хаягдлын ангилан ялгалт .....	6
Зураг 15. Аюултай хог хаягдлын ангилан ялгалт .....	6
Зураг 16. Аюултай хог хаягдлын бүртгэл .....	6
Зураг 17. Аюултай хог хаягдлын дахин ашиглалт .....	6
Зураг 18. Хаягдал дугуйн дахин ашиглалт .....	6
Зураг 19. Хог хаягдлын бүх нийтийн цэвэрлэгээ .....	6
Зураг 20. Сум орон нутгийн хог хаягдлын бүх нийтийн цэвэрлэгээ .....	6
Зураг 21. Уур амьсгалын сургалт .....	6
Хүснэгтийн жагсаалт .....	6
Хүснэгт 1. Гаалийн хяналтын талбайн тоосны хэмжилтийн үр дүн .....	6
Хүснэгт 2. Гаалийн хяналтын талбайн тоосны хэмжилтийн үр дүн .....	6
Хүснэгт 3. Ажилчдын хотхоны талбайн тоосны хэмжилтийн үр дүн .....	6
Хүснэгт 4. Ажилчдын хотхоны дотоод талбайн тоосны хэмжилтийн үр дүн .....	6
Хүснэгт 5. Ажилчдын хотхоны энгийн хог хаягдлын бүртгэл .....	7
Хүснэгт 6. Гаалийн хяналтын талбайн энгийн хог хаягдлын бүртгэл .....	7
Хүснэгт 7. Эмнэлгийн хог хаягдлын бүртгэл .....	7
Хүснэгт 8. Бүх нийтийн цэвэрлэгээний хог хаягдлын бүртгэл .....	7
Хүснэгт 9. Усны химийн шинжилгээний үр дүн .....	7
Хүснэгт 10. Усны нян судлалын шинжилгээний үр дүн .....	7

---

Хүснэгт 11. Ханги ажилчдын хотхоны усны химийн шинжилгээний үр дүн .....	7
Хүснэгт 12. Гаалийн хяналтын талбайн хөрсний шинжилгээний үр дүн .....	7
Хүснэгт 13. Ханги кемпийн талбайн хөрсний шинжилгээний үр дүн.....	7
Графикийн жагсаалт .....	7
График 1. Ханги кемпийн худгийн усны химийн шинжилгээний харьцуулалт.....	7
График 2. Гаалийн хяналтын талбайн урвалын орчин болон ялзмагийн хэмжээ .....	7
График 3. Гаалийн хяналтын талбайн хүнд элементийн бохирдлын төвшин.....	7
<b>1. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕ ШАТНЫ ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>8</b>
1.1. Төслийн товч танилцуулга .....	8
1.2. Төслийн гүйцэтгэлийн өнөөгийн төвшин.....	8
<b>2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>8</b>
2.1. Агаар орчин хамгаалал.....	8
2.1.1. Нүүрс тээврийн хөдөлгөөний нэгдсэн маршрут .....	8
2.1.2. Хурдны хязгаар болон зорчих хэсгийн тэмдэгжүүлэлт.....	8
2.1.3. Тээврийн замын усалгаа.....	8
2.1.4. Цаг агаарын урдчилсан мэдээлэл .....	9
2.1.5. Агаарын нарийн ширхэглэгт тоосны хэмжилтийн үр дүн .....	9
2.2. Усны чанар болон нөөцийн хамгаалал.....	11
2.2.1. Төслийн ус ашиглуулах дүгнэлт болон захирамж, гэрээ .....	11
2.2.2. Усны чанарын хяналтын биелэлт .....	11
2.2.3. Ус ашиглалт болон төлбөр барагдуулалтын байдал.....	12
2.3. Хөрсөн бүрхэвчийг хамгаалал .....	12
2.3.1. Хөрсний бохирдлын хяналт судалгаа.....	12
2.3.2. Асгаралтын сургалт .....	14
2.3.3. Асгаралт саармагжуулах арга хэмжээ.....	15
2.4. Газрын хэвлий хамгаалал .....	18
2.5. Биологийн олон янж байдлын хамгаалал .....	18
2.5.1. Амьтны мониторингийн үр дүн.....	18
<b>3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>22</b>
3.1. Мод тарилтын тайлан .....	22
<b>4. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>25</b>
4.1. Түүх соёлын өвийг хамгаалах сургалт, зурагт постер.....	25
<b>5. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....</b>	<b>25</b>
5.1. Байгаль орчны ажлын байрны үзлэгийн дүн.....	25
5.2. Дотоод аудитын үр дүн.....	25
5.3. Байгаль орчны зөрчлийн хяналтын үр дүн.....	26

<b>6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	26
6.1. Энгийн хог хаягдлын менежмент .....	26
6.2. Аюултай хог хаягдлын хяналт .....	28
6.3. Бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээ .....	30
6.4. Сум орон нугийн хог хаягдлын цэвэрлэгээ.....	31
<b>7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ</b> .....	32
7.1. Усны хяналт, шинжилгээний дүн .....	32
7.2. Хөрсний бохирдлын хяналт шинжилгээний дүн .....	36
<b>8. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	39
<b>9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ</b> .....	40
<b>10. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 2023 БИЕЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ</b> .....	40
Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Агаар орчныг хамгаалах чиглэлд 7 заалт бүхий ажлыг <b>100%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа. ....	40
Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Усны нөөц болон чанарыг хамгаалах чиглэлд 11 заалт бүхий ажлыг <b>90%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа. ....	41
Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Хөрс хамгаалах чиглэлд 13 заалт бүхий ажлыг <b>80%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа. ....	42
Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – газар, түүний хэвлийг хамгаалах чиглэлд 3 заалт бүхий ажлыг <b>100%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа. ....	43
Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлд 7 заалт бүхий ажлыг <b>100%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа.....	43
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн чиглэлд 2 заалт бүхий ажлыг <b>100%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа. ....	44
Түүх соёлын өвийг хамгаалах чиглэлд төлөвлөл байхгүй байсан хэдий ч Түүх, соёлын өвтэй холбоотой зурагт постеруудыг бэлтгэн шаардлагатай газруудад байршуулсан. ....	44
Осол эрсдэлийн менежментийн ажлын биелэлтийг 100% тай хэрэгжүүлэн ажиллалаа. ....	44
Хог хаягдлын менежментийн чиглэлд 11 заалт бүхий ажлыг <b>90%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа. ....	44
<b>Үүнд:</b> .....	44
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын чиглэлд 4 заалт бүхий ажлыг <b>80%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа.....	45
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын ажлын чиглэлд 19 заалт бүхий ажлыг <b>80%</b> тай хэрэгжүүлэн ажиллалаа.....	46
<b>Ерөнхий дүгнэлт:</b> .....	47

## 1. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮЕ ШАТНЫ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн товч танилцуулга

Төсөл хэрэгжих талбай нь “Тавантолгой-Манлай-Ханги” чиглэлийн нүүрс тээврийн авто замын 461-463 дахь километр Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн нутаг дэвсгэрт 80.0 га талбайг эзэмшихээр төлөвлөжээ. Төслийн хүчин чадал нь 300-350 ш хүнд даацын автомашины зогсоол, ажилчдын кемп нь 1200 ажилчдыг байршуулахаар төлөвлөсөн байна.

Гаалийн хяналтын талбай нийт 80 га, Ханги ажилчдын хотхон 15 га газрыг тус тус эзэлнэ.

“Гаалийн хяналтын талбай, ажилчдын хотхон, авто бааз байгуулах” төсөл нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн хилийн заагт хэрэгжинэ. Тус бүс нутгийн онцлог нь говь-цөлийн бүс нутаг бөгөөд цөлжилт эрчимтэй явагдаж буй хуурайшилт, шороон шуурга ихтэй бүс юм.

Төсөл хэрэгжих үеийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх гол сөрөг нөлөөлөл нь орон нутгийн шороон замаар тээвэрлэлт хийснээс агаарт тоосжилт үүсэх, нүүрс ил задгай тээвэрлэх, нүүрс бүтээсэн бүтээлэгний битүүмж алдагдах үед нүүрсний нунтаг тоосонцор агаарт тархах зэрэг бүс нутгийн эмзэг байдалд нөлөөлөх, тээврийн хэрэгслийн утаа болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт, тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн дуу чимээ зэрэг байхаар байна.

### 1.2. Төслийн гүйцэтгэлийн өнөөгийн төвшин

Төслийн үндсэн үйл ажиллагаа болох Тавантогойн ордоос нүүрсийг тээвэрлэх, жинлэх, гаалийн хяналтын талбайд буулгах, түр хадгалах, Ханги боомт руу ачилт хийх зэрэг үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Ханги ажилчдын хотхонд богинын тээвэр буюу гаалийн хяналтын талбайгаас Ханги боомт руу тээвэр гүйцэтгэх жолоочдыг байрлуулах, амраах зориулалтаар кемпийн үйл ажиллагаа явуулж байна.

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

### 2.1. Агаар орчин хамгаалал

#### 2.1.1. Нүүрс тээврийн хөдөлгөөний нэгдсэн маршрут

Нүүрс тээврийн богино болон холын тээвэрт явах хөдөлгөөнт техникийн замын хөдөлгөөний дүрмийг гаргаж, нийт жолооч нарт зааварласан.

#### 2.1.2. Хурдны хязгаар болон зорчих хэсгийн тэмдэгжүүлэлт

Нүүрс тээврийн ачиж буулгах талбай болон авто жингийн хэсгүүдэд хурдны хязгаар болон бусад уамын хөдөлгөөний анхааруулах тэмдгүүдийг байршуулж өгсөн.

#### 2.1.3. Тээврийн замын усалгаа

Нүүрс тээврийн технологийн замын тоосжилтын төвшинг бууруулах зорилгоор өдөр болон шөнийн ээлжинд замын усалгааг тогтмол гүйцэтгэсэн бөгөөд 2023 оны туршид нийт **2880 тон** усыг нарийн ширхэгтэй тоосжилт дарахад ашигласан байна.

#### 2.1.4. Цаг агаарын урдчилсан мэдээлэл

Нүүрс тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааг цаг агаарын нөхцөлтэй уялдуулан гүйцэтгэж ажилласан бөгөөд шаардлагатай цаг агаарын сэрэмжтэй нөхцөлд төслий үйл ажиллагааг тодорхой хугацаатай зогсоон ажиллалаа.

#### 2.1.5. Агаарын нарийн ширхэглэгт тоосны хэмжилтийн үр дүн

Агаарын нарийн ширхэгт тоосонцорын хэмжилт, дуу чимээ, дэгдэмхий бодисын хэмжээ болон формальдгидийн хэмээг гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхон дотор сар бүр гүйцэтгэсэн бөгөөд уртын болон богинын тээвэртэй, тээвэргүй үед хяналтын цэгт хэмжсэн үр дүнгийн дунджийг дараах хүснэгтээр харуулав.

Хэмжилтйн цэгийн байршил	Үзүүлэлтийн нэр	Хугацаа /мин/	Хэмжих нэгж	Стандарт утга	Хэмжигдсэн утга	Тайлбар
Авто пүү, нүүрс ачиж буулгах цэгийн орчимд	PM 10	10 мин	мкг/м <sup>3</sup>	0-50	42	Уртын болон богинын ачаа тээвэргүй үеийн хэмжилтийн үр дүн
	PM 2.5	10 мин	мкг/м <sup>3</sup>	0-35	22	
	Агаарын чийгшил	10 мин	мкг/м <sup>3</sup>	30-60	33	
	Дуу чимээ	10 мин	дБа	45-60	52	
	Салхины хурд	10 мин	м/сек		7	
	Агаарын температур	10 мин	Т <sup>0</sup>		19-26	
	TVOC	10 мин			6	
	НСНО	10 мин			0	

Хүснэгт 1. Гаалийн хяналтын талбайн тоосны хэмжилтийн үр дүн

Хэмжилтйн цэгийн байршил	Үзүүлэлтийн нэр	Хугацаа /мин/	Хэмжих нэгж	Стандарт утга	Хэмжигдсэн утга	Тайлбар
Авто пүү, нүүрс ачиж буулгах цэгийн орчимд	PM 10	10 мин	мкг/м <sup>3</sup>	0-50	60	Уртын тээвэргүй богинын тээвэртэй үеийн хэмжилтийн үр дүн
	PM 2.5	10 мин	мкг/м <sup>3</sup>	0-35	55	
	Агаарын чийгшил	10 мин	мкг/м <sup>3</sup>	30-60	21	
	Дуу чимээ	10 мин	дБа	45-60	75	
	Салхины хурд	10 мин	м/сек		6-9	
	Агаарын температур	10 мин	Т <sup>0</sup>		19-23	
	TVOC	10 мин			9	
	НСНО	10 мин			11	

Хүснэгт 2. Гаалийн хяналтын талбайн тоосны хэмжилтийн үр дүн

Дээрх 2 төрлийн хэмжилтээс дүгнэвэл уртын болон богинын тээвэр зэрэг явагдаж байгаа үед тоосжилтын төвшин өндөр, агаарын чанарын элементүүд бүгд стандарт давсан үзүүлэлттэй гарч байна.

Иймд доор дурьдсан арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллалаа.

- ξ Гадаад орчинд ажиллаж буй ажилтан бүрт амьсгал хамгаалах хэрэгслийг тогтмол зүүж, хэвшүүлэх
- ξ Тоосжилт дарах усалгааг нэмэгдүүлэх
- ξ Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед 20 сек-ийн дүрмийг мөрдүүлэх
- ξ Агаарын хэмжилтийг суурин хийж гүйцэтгэх
- ξ Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг байсан.

Ханги ажилчдын хотхоны дотоод орчинд хэмжигдсэн нарийн ширхэгтэй тоосжилтын үр дүнг доорх хүснэгтэд харуулав.

Хэмжилтйн цэгийн байршил	Үзүүлэлтийн нэр	Хугацаа /мин/	Хэмжих нэгж	Стандарт утга	Хэмжигдсэн утга	Тайлбар
Кемпийн дотоод орчин	PM 10	10 мин	мкг/м <sup>3</sup>	0-50	10	Хур тунадас орсны дараах үеийн хэмжилтийн үр дүн
	PM 2.5	10 мин	мкг/м <sup>3</sup>	0-35	4	
	Агаарын чийгшил	10 мин	мкг/м <sup>3</sup>	30-60	42	
	Дуу чимээ	10 мин	дБа	45-60	23	
	Салхины хурд	10 мин	м/сек		5	
	Агаарын температур	10 мин	Т <sup>0</sup>		18	
	TVOC	10 мин			0	
НСНО	10 мин			0		

Хүснэгт 3. Ажилчдын хотхоны талбайн тоосны хэмжилтийн үр дүн

Хэмжилтйн цэгийн байршил	Үзүүлэлтийн нэр	Хугацаа /мин/	Хэмжих нэгж	Стандарт утга	Хэмжигдсэн утга	Тайлбар
Кемпийн дотоод орчин	PM 10	10 мин	мкг/м <sup>3</sup>	0-50	23	Хуурайшилт ихтэй үеийн хэмжилтийн үр дүн
	PM 2.5	10 мин	мкг/м <sup>3</sup>	0-35	32	
	Агаарын чийгшил	10 мин	мкг/м <sup>3</sup>	30-60	26	
	Дуу чимээ	10 мин	дБа	45-60	22	
	Салхины хурд	10 мин	м/сек		6-9	
	Агаарын температур	10 мин	Т <sup>0</sup>		19-23	
	TVOC	10 мин			0	
НСНО	10 мин			0		

Хүснэгт 4. Ажилчдын хотхоны дотоод талбайн тоосны хэмжилтийн үр дүн

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ-ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



## 2.2. Усны чанар болон нөөцийн хамгаалал

### 2.2.1. Төслийн ус ашиглуулах дүгнэлт болон захирамж, гэрээ

Төслийн хувьд ус ашиглалтын байдалд хууль эрхзүйн дараах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа.

- БОАЖС-ын 2021 оны 7-р сарын 9-ний өдрийн 01/3144 дугаар бүхий ай савын лавлагаатай.
- Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 5-р сарын 24-ний өдрийн 253 дугаар бүхий Ус ашиглуулах дүгнэлттэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын 2023 оны 6-р сарын 29-ний өдрийн А/126 дугаар бүхий Ус ашиглуулах зөвшөөрөлтэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны 6-р сарын 29-ний өдрийн Ус ашиглуулах гэрээтэй.
- Галба-Өөш-Долоодын сав газрын 2023 оны 4-р сарын 03-ны өдрийн 2023/01 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэг тогтоох дүгнэлттэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргын 2023 оны 10-р сарын 4-ний өдрийн А/172 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэгийн зөвшөөрөлтэй.
- 2023 оны 1-р сарын 23-ны өдөр баталгаажсан LXLG-40 загварын 16м3/ц хэмжилтийн хязгаартай, 40 мм голчтой, 202000311 дугаартай, 047 дугаар бүхий лацтай тоолуурыг 2023 оны 1-р сарын 26-ны өдөр суурилуулсан.

### 2.2.2. Усны чанарын хяналтын биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд усны химийн болон нян судлалын шинжилгээг төслийн байгаль орчны алба “Земпроект” ХХК-тай хамтран гүйцэтгэсэн.

#### Гаалийн хяналтын талбайн худгийн хувьд:

Ус зүйн шинжилгээ НАБТ орчмын уснаас сульфат 1343 мг/л, натри 369 мг/л, магни 134 мг/г, кальцийн 69 мг/г хэмжээ тус бүр Монгол улсын ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын MNS0900:2018- стандартын зөвшөөрөгдөх дээд стандартаас хэтэрсэн ба эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байгаа тул ахуйн хэрэглээнд хэрэглэвэл аюултай болно. Химийн бүрэлдэхүүнээрээ: Сульфатын анги, натрийн бүлэг, 3 төрлийн давстай буюу шорвогдуу, маш хатуу ус бөгөөд зайлшгүй унданд хэрэглэх тохиолдолд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.

Ханги НАБТ, Дорноговь аймаг, Хатанбулагийн гүний худгийн усны дээжийг “Нарт шуун консалтинг” ХХК итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. Усны шинжилгээний дүнг нэгтгэн байдлаар орчны хяналт шинжилгээний хэсэгт дэлгэрэнгүй танилцуулав.

#### Боомтын худгийн хувьд:

2023 оны цэвэр усны шинжилгээний хариунаас дүгнэхэд Ханги төслийн талбайн ажилчдын ундны усны эх үүсвэр болох “Боомтын худаг”-ийн хариу нь Монгол Улсын MNS 0900:2018 стандартын хэмжээнд байгаа боловч энэ бүс нутгийн усны рН **7,21-8,44** байгаа үзүүлэлт нь шүлтлэг чанар өндөртэй болохыг харуулж байна.

Мөн Уран, Селен, Никель Кадми, Берелли зэрэг хүнд элементийн үзүүлэлт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү байна.

Тус бүс нутгийн эрдэжилт өндөртэй усыг хүнсэнд хэрэглэх үед биеийн ерөнхий тав тух алдагдах, ам цангах, биеийн хүчил шүлтийн тэнцвэр өөрчлөгдөх, зүрхний ажиллагаа сулрах, ходоод гэдэсний архаг зарим өвчин хурцдах зэрэг шинж тэмдгүүд илэрнэ.



Мөн эмч нарын үзэж байгаагаар цусны эргэлтийн тогтолцооны өвчнүүд /ЦЭТӨ/ тухайлбал цусны даралт ихсэх, зүрхний шигдээс, атеросклероз /судас хатуурах/, хоол боловсруулах эрхтний өвчнүүд /ХБЭӨ/ тухайлбал ходоод, нарийн бүдүүн гэдэсний үрэвсэлт өвчнүүд, элэг цөсний архаг өвчин мөн бөөр шээсний замын чулуужих өвчин /БШЗЧӨ/ зэрэг нь эрдэсжилгээс шалтгаалах өвчин эмгэгт хамаардаг байна.

Иймд катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглах, буцалгаж хэрэглэх нь эрүүл мэндэд чухал ач холбогдолтой.

Усны шинжилгээний дүнг нэгтгэн байдлаар орчны хяналт шинжилгээний хэсэгт дэлгэрэнгүй танилцуулав.

### 2.2.3. Ус ашиглалт болон төлбөр барагдуулалтын байдал

Нийт ашиглах усны хэмжээ : **4122.5м3**, Унд ахуйн хэрэгцээнд : **1020.0м3**, Зам талбайн тоосжилт дарах зориулалтаар : **3102.5м3** ус ашиглахаар төлөвлөгдсөн.

Ханги кемпийн “Ажилчдын байр, автобааз, гаалийн хяналтын талбайг” төслийн ажилчдын хэрэглээний усаар хангадаг LXLG-10 тоолууртай гүний худаг ашигладаг. Тус худгийн тоолуурыг стандарт хэмжилзүйн лабораториор баталгаажуулан үйл ажиллагаанд хэрэглэж байна. 2023 оны тоолуурын заалтад тулгуурлан төлбөрийг сумын татварын алба тооцож, нэхэмжлэх гаргуулан нэхэмжлэлийн дагуу ус ашигласны төлбөрт **1 сая** төгрөгийг төлж барагдуулсан.

## 2.3. Хөрсөн бүрхэвчийг хамгаалал

### 2.3.1. Хөрсний бохирдлын хяналт судалгаа

Хөрс газарзүйн мужлалаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Говийн мужийн Говийн цайвар бор, Цөлийн бор саарал хөрс бүхий 12-р тойрогт багтана. Говийн цайвар бор зонхилон тархах бөгөөд сайр дагаад Элсэнцэр бор саарал хөрстэй. Ерөнхий хөрсөн бүрхэвч нь доворхог хад чулуурхаг газрын гадаргын байдлаас шалтгаалж алаг цоог, хоршил зонхилно. Өндөрлөгдүү уулархаг газраар нимгэн чулуурхаг, хотгордуу газраар ердийн Говийн цайвар бор хөрстэй. Хойд хэсгээр нимгэн чулуурхаг хөрстэй байхад, урд хэсгийн хотгордуу газраар элсэрхэг дов ихтэй элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нэлээд их талбай эзэлж байна. Хотгордуу газраар мараалаг хужирлаг шинжийн давсархаг хөрс хам бүрдэл үүсгэж бага зэрэг талбай эзэлнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хөрсний хүнд эльментийн бохирдол болон шимэрхэг байдлын шинжилгээг төслийн байгаль орчны алба “Земпроект” ХХК-тай хамтран гүйцэтгэсэн.

Хөрсний агрохимийн 1 дээжийг 300-500 гр, хүнд металлын 1 дээжийг 200-300 гр хэмжээтэй, эрүүл ахуйн 1 дээжийг 300-500 гр хэмжээтэй тус бүр авсан.

Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн дагуух Гаалийн хяналтын талбай нь Дорноговь аймгийн Хатанбулаг суманд байрлах бөгөөд цөлөрхөг хээрийн хужирлаг бор хөрстэй. Хөрсний онцлог нь хөрсний бүх давхаргад хатхаараа гялтганаж харагдах. Хөрсний үржил шимт үе давхаргын ялзмагийн агууламж 1.05-1.45%, хөдөлгөөнт кали 16-20 мг/100гр, хөдөлгөөнт фосфор 1.9-3 мг/100гр байгаа нь хөрсний үржил шимийн түвшин бага байгааг илтгэх бөгөөд карбонатын (CaCO<sub>3</sub>) агууламж 0.-2.24 %, ууссан хүчилтөрөгч (рН) 8.37-8.70 хөрсний үржил шимийн түвшин говийн хөрсөндөөдунд зэргийн үзүүлэлт боловч хялбар уусах давсны агууламж өндөр, шүлтлэг урвалын орчинтой учир ургамалд хаалт үүсгэх гол шалтгаан юм.

Гаалийн хяналтын талбай орчмын хөрсний хүнд металлын шинжилгээгээр 6 төрлийн химийн хүнд металл болох никель, кадми, хар тугалга, цайр, хром болон зэс нь MNS5850:2019 стандартын элсэрхэг хөрсөнд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй тул бохирдолгүй.

НАБТ орчимын хөрсний дээж авсан цэгүүд



Зураг 1. Гаалийн хяналтын талбайн хөрсний мониторингийн цэгийн байршил

### 2.3.2. Асгаралтын сургалт

Асгаралтын тухай ажилчдад чиглүүлэх сургалтыг ХЭМАБО хэлтсээс зохион байгуулж, сургалтанд Засварын хэлтсийн 15 ажилтан, Тээврийн хэлтсийн 27 ажилтан хамрагдав. Сургалтын гол чиглэл шатах тослох материал гэж юу вэ, нэр томъёо, хуулийн зүйл заалтууд, асгаралтын сөрөг үр дагавар, асгаралтын үед авах арга хэмжээг хэрхэн үр дүнтэй менежменттэй зохион байгуулах, асгаралтын мэдээлэх нь байгаль орчиндоо хайртай иргэн бүрийн хувь нэмэр гэсэн агуулгын хүрээнд удирдан зохион байгуулав. Мөн асгаралтыг хянах газрын тосны гаралтай болон бусад синтезийн гаралтай химийн бодисоор бохирдсон хөрс усыг хэрхэн цэвэрлэх, асгаралтын иж бүрдлийг хэрхэн зөв ашиглах зэрэг сэдвийн хүрээнд сургалтыг явууллаа.

Сургалтын үйл явц



Зураг 2. Асгаралтын сургалт

### 2.3.3. Асгаралт саармагжуулах арга хэмжээ

Ханги төслийн талбайн хувьд нүүрстөрөгчийн асгаралт харьцангуй бага гардаг боловч асгаралт гарч хөрс бохирдсон тохиолдолд асгаралтын журмыг баримтлан ажиллаж бохирдсон хөрсийг дараах аргаар саармагжуулалт хийнэ.

- Асгаралт гарсан тохиолдолд өөрсдийн хариуцсан ахлах ажилтан буюу томилсон ажилтанд даруй мэдэгдэх.
- Гүйцэтгэхэд аюулгүй бөгөөд зохих ХХХ-ийг өмссөн тохиолдолд асгаралтыг шингээгч материал ашиглаж даруй цэвэрлэж эхлэх.
- Ямар нэг хэвийн бус ажиллагаа эсвэл асуудлыг өөрсдийн хариуцсан ахлах ажилтан болон байгаль орчны ажилтанд мэдээлэх

Хөрс цэвэрлэх байгууламжийн агааржуулалт:


- Хөрс цэвэрлэх байгууламж нь механик агааржуулалт хийх замаар биологийн задралыг оновчтой болгох орчин бүрдүүлж бохирдсон элс, хайрга болон хөрсөн дэх газрын тосон суурьт бүтээгдэхүүний био задралын явцыг түргэсгэх зориулалттай болно.
- Бохирдсон хөрсийг хөрс цэвэрлэх байгууламж дээр нэмж хийнэ. Зуны улиралд бохирдуулагчийг задлах зорилгоор тодорхой био нүхийг нэмэлтээр бэлтгэнэ.

Хөрс цэвэрлэх үйл явцаар цэвэрлэх боломжтой хөнгөн нүүрстөрөгчүүд: -бензин, дизель, керосин бусад боловсруулсан, цэвэр бөгөөд хагас цэвэр бөгөөд хагас ууршимтгай газрын тосонд суурилсан бүтээгдэхүүнүүд


Хөрс цэвэрлэх үйл явцаар цэвэрлэх боломжгүй хүнд нүүрстөрөгчүүд: - моторын тос болон тосол, гидравлик хаягдал тос, бусад хаягдал тос орно.

- Хөрсний зузаан 30 см-ээс их тохиолдолд механик аргаар хазайлгах буюу агааржуулах хоолой хэрэглэх шаардлагатай;
- Улирал: Хөрс хөлдөөгүй үед буюу 5 сараас 9 сарын хооронд
- Цаг уур: Салхины хурд ихтэй өдрүүдэд агааржуулалтыг хийж болохгүй;
- Тоног төхөөрөмж: Тухайн жилийн овоолгыг агааржуулахын тулд жижиг бульдозер буюу гар аргаар
- Давтамж: Сард нэг удаа (хөрс хөлдөөгүй нөхцөлд);
- Овоолго чийгтэй байгаа эсэхийг шалгах боловч био цэвэрлэгээ хийхийн тулд материалыг барихад үл ялиг чийгтэй, үл ялиг барьцалдсан байна.
- Био нөхөн сэргээлтийн үйл явцыг сайжруулахын тулд цэвэрлэх овоолго руу тодорхой төрлийн хөрсний тэжээлийн бодисыг нэмж болно. Шүүрэлтээс цуглуулсан нитратаар баялаг усыг нэмэх замаар хөрс цэвэрлэх байгууламжийг бордож болно.
- Давтамж: Бордолтын давтамжийг баталгаажуулахын тулд лабораторийн шинжилгээний хариу ашиглаж байгаль орчны хэлтсээс шинжилгээ хийх боловч бордолтыг жилд нэг удаа эсвэл сард нэг удаагийн давтамжтайгаар гүйцэтгэж болно.

• Услалт: Зуны улирлын турш чийгний түвшинг хангалттай хэмжээнд байлгахын тулд шаардлагатай тохиолдолд хөрс цэвэрлэх байгууламж руу цэвэр ус хийж болно. Хэрэв боломжтой бол, нитрат ихээр агуулсан, хөрсөн дэх микроорганизмыг идэвхижүүлэх боломжтой усыг ашиглана.



Зураг 3. Ханги ажилчдын хотхон – Асгаралтын бүртгэл



Зураг 4. Гаалийн хяналтын талбай – Асгаралтын бүртгэл

#### 2.4. Газрын хэвлий хамгаалал

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бүхий хэсгийн газрууд холбогдох зөвшөөрлийн хүрээнд зориулалтын дагуу ашиглагдаж байна. Холбогдох төлбөрүүд Хатанбулаг сумын татварын албанд төлөгдөж байна.

Аливаа төслийн бүтээн байгуулалтын үед шинээр газар хөндөхөөр бол байгаль орчны багаас урдчилан зөвшөөрөл авна.

#### 2.5. Биологийн олон янж байдлын хамгаалал

##### 2.5.1. Амьтны мониторингийн үр дүн

Амьтны мониторинг судалгааг сар бүр нийт **10** удаагийн давтамжтай өдөр болон шөнийн цагт Ханги ажилчдын хотхон болон гаалийн хяналтын талбайд дараах амьтдын төрөл зүйл бүртгэгдсэн.

Гаалийн хяналтын ашиглалтын үйл ажиллагааны талбайд дараах амьтад бүртгэгдэв.

- ξ Хонин гүрвэл
- ξ Цоохор гүрвэл
- ξ Хар хорхой
- ξ Алагдаахай
- ξ Талын жиргэмэл шувуу
- ξ Хотны бүгээхэй шувуу
- ξ Хон хэрээ зэрэг амьтад өдөр шөнийн цагт бүртгэгдэв.






Зураг 5. Амьтны тооллого судалгаа



Ханги ажилчдын хотхоны ойр орчимд дараах төрлийн амьтад бүртгэгдсэн.





- ξ Хонин гүрвэл
- ξ Цоохор гүрвэл
- ξ Хар хорхой
- ξ Алагдаахай
- ξ Дэлдэн зараа
- ξ Молтогчин туулай
- ξ 3 зүйл могой
- ξ Хон хэрээ зэрэг амьтад өдөр шөнийн цагт бүртгэгдэв.

Ургамлын мониторинг судалгааг улирал тутамд нийт 4 удаа Ханги ажилчдын хотхон болон гаалийн хяналтын талбайд гүйцэтгэсэн бөгөөд дараах төрлийн ургамлууд бүртгэгдсэн.

№	Ургамлын нэр	Зураг	Бүрхэц %	Ховрын статус
1	Үслэг манан хамхаг		Ашиглалтын талбайн 12 %-д тархсан.	Цөлөрхөг хээрийн унаган ургамал
2	Тажийн жинс (Лам тархи/Адуун уруул)		Ашиглалтын талбайн 0,07 %-д тархсан.	Цөлөрхөг хээрийн унаган ургамал Ховор статустай
3	Залаархаг хавраг буюу чийрийн давирхай”		Ашиглалтын талбайн 1.2 %-д тархсан.	Заримдаг цөлийн унаган ургамал

4	Хуурайсаг шарилж буюу Бор шаваг		Ашиглалтын талбайн 7 %-д тархсан.	Заримдаг цөлийн унаган ургамал
---	------------------------------------	---	---	--------------------------------------

Зураг 6. Гаалийн хяналтын талбайн ургамлын мониторинг

№	Ургамлын нэр	Зураг	Бүрхэц %	Ховрын статус
1	Үслэг манан хамхаг		Ашиглалтын талбайн 12 %-д тархсан.	Цөлөрхөг хээрийн унаган ургамал
2	Тажийн жинс (Лам тархи/Адуун уруул)		Ашиглалтын талбайн 0,07 %-д тархсан.	Цөлөрхөг хээрийн унаган ургамал Ховор статустай
3	Залаархаг хавраг буюу чийрийн давирхай”		Ашиглалтын талбайн 1.2 %-д тархсан.	Заримдаг цөлийн унаган ургамал
4	Хуурайсаг шарилж буюу Бор шаваг		Ашиглалтын талбайн 7 %-д тархсан.	Заримдаг цөлийн унаган ургамал

	<p>Ямаан ангалзуур</p>		<p>Ашиглалтын талбайн 1.2 %-д тархсан.</p>	<p>Цөлөрхөг хээрийн унаган ургамал Ховор статустай</p>
--	------------------------	---	--	--

Зураг 7. Ханги кемпийн ургамлын мониторингийн үр дүн

Цаашид тухайн ашиглалтын талбайд газар хөндөхөөр бол Байгаль орчны багаас урдчилсан зөвшөөрөл өгч газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлнэ.

Байгалийн ургамлын тухай хуулийн 15.2, 16.1, 17.3 хэсэгт дэлгэрэнгүй заасанчлан байгалийн ховор, нэн ховор ургамлыг зөвшөөрөлгүйгээр түүж бэлтгэхийг хориглох тухай заалтыг төслийн талбайд ажиллаж буй ажилчдад танилцуулан, холбогдох зурагт постерийг хэвлэн, шаардлагатай газруудад байршууллаа.



Зураг 8. Байгаль орчны зурагт постерууд

### 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

#### 3.1. Мод тарилтын тайлан

Төслийн талбай нь “Тавантолгой-Манлай-Ханги” чиглэлийн нүүрс тээврийн авто замын 461-463 дахь километр Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн нутаг дэвсгэрт **80.0 га** бүхий талбай юм. Гаалийн хяналтын талбай нь нүүрс тээвэр, ачилт буулгалтаас үүдсэн ургамлын масс, ногоон байгууламжийн талбай багасах шалтгаан болж байна.

Байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөнд орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх ажлыг жил бүр тогтмол тусган, оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

“Тахилт хайрхан транс ХХК-ийн Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багийн нутагт байрлах “гаалийн хяналтын талбай, ажилчдын хотхон, автобааз төсөл”-ийн 2023 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэх, Монгол улсын ерөнхийлөгчийн 63-р тоот зарлиг, Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний дагуу мод тарих ажлыг хийж гүйцэтгэв.



Зураг 9. Гаалийн хяналтын талбайн мод тарилтын ажил

Гаалийн хяналтын талбайд тухайн орчны хөрс байгаль цаг уурын төлөв байдалд тохирсон дараах модыг тарьсан. Модны суулгац тарих нүхний диаметр 50-60см, гүн 60-70см, мод хоорондын зай 1,7-2м зайтай тарьсан. Үүнд:

- Сухай – TAMARIX L

Сухай нь говь цөлийн мод бөгөөд элс бэхжүүлэх чадвар өндөртэй юм. Сухай нь жилд 2-3 удаа цэцэглэх тул говь, цөл нутгийн төв суурин газрын цэцэрлэгжүүлэлтэд чимэглэлийн өндөр ач холбогдолтой. Сухай нь хар өнгийн хайрс маягийн навчтай маш нягт хатуу, гоёмсог, хээлж судалтсан модлогтой шаталт, илч сайтай, гэрэлд дуртай, халуун ба хужир давс сайн тэсвэрлэдэг. Сухай элсэнд дарагдах тусмаа ичмэл нахианаас сэргэн ургах чадвар нэмэгддэг биологийн онцлогтой.

Гаалийн хяналтын талбайд нийт **25ш** Сухай тарьсан.

Түүнчлэн, Хайлаас нь Монгол орны хангай, говь, хээрийн бүсэд ургадаг мод юм. Хайлаас нь хавар навч дэлгэрхээс өмнө цэцэглэж үрлэнэ. Хайлаас нь ганд тэсвэртэй, сайтар усалж арчлахад үндэснээсээ амархан сэргэн ургадаг.

Гаалийн хяналтын талбайд нийт **15ш** Хайлаас тарьсан.



Зураг 10. Ханги ажилчдын хотхоны талбайн мод тарилтын ажил

Мөн Ханги ажилчдын хотхонд 2023 оны 10 сарын 31-11 сарын 6 өдөр хүртэл **100** ширхэг хайлаас, **25** ширхэг нарсны суулгацыг кемпийн хашаанд тарилаа.

2022 оны хаврын тарилтийн суулгацуудын ургалт **50%-тай** байгаа бөгөөд усалгааний хуваарийн дагуу хурц нартай болон их халууны улиралд долоо хоногт 3 удаа өглөө оройн сэрүүнд 30-40л усаар усалж бага халууны улиралд долоо хоногт 2 удаа 40-50л усаар усалж байв. Бордоо болгон өндөгний хальс, бууцыг усанд дэвтээн усалгаа болгоны хооронд нэмэлтээр хийж байлаа.

Цэнэг усалгааг 2 удаа хийж цасаар манав.

Цаашид ажилчдын амьдрах, амрах таатай орчинг бүрдүүлэхийн тулд орчны ногоон байгууламжиндаа амьдрах чадвар сайтай, ус бага хэрэглэдэг шар хуайсыг үрээр тариалах төлөвлөгөөтэй байна.



Зураг 11. Ханги ажилчдын хотхоны модны арчилгаа

## 4. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

### 4.1. Түүх соёлын өвийг хамгаалах сургалт, зурагт постер



“Тахилт хайрхан транс” ХХК-ийн байгаль орчны албанаас түүх соёлын өвийг хамгаалах ажлыг сурталчлан таниулах, соёлын биет өв олдвол ажлаа зогсоож, байгаль орчны багт мэдээллийг хүргэх, авран хамгаалах зэрэг ажлыг нийт гэрээлэгчдэд танилцуулсан.

Зураг 12. Соёлын өвийг хамгаалах тухай зурагт постер

## 5. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 5.1. Байгаль орчны ажлын байрны үзлэгийн дүн

Байгаль орчны багийн дотоод ажлын байрны үзлэгийг 2023 оны 4-р сараас эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд Гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхоны дотоод болон гадаад орчинд нийт **10 удаа** хийж гүйцэтгэсэн. Үзлэгээр байгаль орчны ижил төрлийн нийт **36** зөрчил, дутагдлыг илрүүлж холбогдох хэсгийн удирдах ажилтанд илгээж, сайжруулалтуудыг гүйцэтгүүлэн.



Зураг 13. Байгаль орчны дотоод ажлын байрны үзлэг

### 5.2. Дотоод аудитын үр дүн

Байгаль орчны баг болон хэлтэс нэгжүүдийн удирдах ажилчид, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэнгүүдтэй хамтарсан байгаль орчны хууль эрхзүйн нийцэлд үнэлгээ өгөх, орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор нийт **4** удаагийн дотоод аудитыг гүйцэтгэж, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

5.3. Байгаль орчны зөрчлийн хяналтын үр дүн  
2023 онд байгаль орчны зөрчил бүртгэгдээгүй.

## 6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 6.1. Энгийн хог хаягдлын менежмент

Гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхон энгийн хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгадаг.

Үүнд:

- Ахуйн хатуу хог хаягдал
- Хуванцар хог хаягдал
- Барилгын хог хаягдал
- Хоолны хог хаягдал
- Ахуйн үнс
- Ахуйн шингэн хаягдал
- Бусад зэргээр ангилан ялгадаг.



Зураг 14. Энгийн хог хаягдлын ангилан ялгалт



Тухайн хог хаягдлуудын гарцыг сар бүр бүртгэн тэмдэглэдэг.

Ахуйн хог хаягдал - Ханги кемп

Хог хаягдал (Тон)	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
Ахуйн хатуу хог	95	90	60	45	50	30	54	80	80	80	85	69	<b>818</b>
Барилгын хог	3	0	0	0	0	0	0	0	0	0	0	3	<b>6</b>
Хоолны хог хаягдал	3	4	2.8	5	2	2.7	2.5	3	2	3	3	6	<b>39</b>
Бусад хог хаягдал	10	10	12	12	10	12	15	2	3	2	2	9	<b>99</b>
Ахуйн үнс	9	24	12	25	7	6	0	0	0	6	8	17	<b>114</b>
Бохир ус	0	600	700	850	750	750	750	800	700	700	800	810	<b>8210</b>

Хүснэгт 5. Ажилчдын хотхоны энгийн хог хаягдлын бүртгэл

Ахуйн хог хаягдал - Гаалийн хяналтын талбай

Хог хаягдал (Тон)	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	10 сар	11 сар	12 сар	Нийт
Ахуйн хатуу хог	22	24	26	25	28	30	31	28	29	28	17	16	<b>304</b>
Бусад хог хаягдал	1	1	2	3	3	4	4	3	4	3	2	2	<b>32</b>

Хүснэгт 6. Гаалийн хяналтын талбайн энгийн хог хаягдлын бүртгэл

2023 оны туршид нийт төслийн хэмжээнд хатуу болон ланdfиллийн хог хаягдал **1253** тоныг Хатанбулаг сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргүүлсэн.

Нийт **39** тон хоолны хог хаягдал болон **114** тон ахуйн үнсний хаягдлыг өөрсдийн хог хаягдлын цэгт ланdfил аргаар булшилсан.

Нийт **8210** тон ахуйн саарал усыг бохир ус хаях зөвшөөрөлтэй цэгтээ хаясан.

Нийт **2500 ш** хуванцар савыг “Чингүүн Марал” ХХК-д хүлээлгэн өгсөн.

Нийт **6** тон орчим хог хаягдлыг Заагийн хогийн цэгт тус тус хаясан байна.

Хатанбулаг сумын ЗДТГ-тай байгуулсан 2023 оны 1-р сарын 23-ны өдрийн Хог хаягдлын гэрээгээр төлбөр **600.000** төгрөг бөгөөд тухайн төлбөрийг барагдуулсан. Түүнчлэн, хог ачилтын төлбөрт нийт **44.330.000** төгрөгийг тус тус төлсөн байна.


### 6.2. Аюултай хог хаягдлын хяналт

Аюултай хог хаягдал үүсгэгчээр албан ёсоор бүртгэгдсэн бөгөөд бүртгэлийн дугаар **001843**. Төслийн хэмжээнд үүсэж буй аюултай хог хаягдлуудыг ангилан ялгах, бүртгэх, эрх бүхий байгууллагад шилжүүлэх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд зарим аюултай хог хаягдлыг нийлүүлэх ажил гэрээний шатанд явагдаж байна.



Зураг 15. Аюултай хог хаягдлын ангилан ялгалт

Аюултай хог хаягдлыг дараах байдлаар ангилсан.



Зураг 16. Аюултай хог хаягдлын бүртгэл

Нийт төслийн хэмжээнд ажилласан тос масло – **10 тон**, хаягдал дугуй – **128 ш**, хаягдал аккумулятор – **37 ш**, тос маслын шүүр – **42 ш**, тос тосолгооны хоосон сав-**160 ш**, тосоор бохирдсон материал – **0,8 тон** орчим байна.

Хатанбулаг сумын засаг даргын 2023 оны 9-р сарын 12-ны өдрийн **01/706** тоот албан хүсэлтийн дагуу **250 ш** хаягдал дугуйг Ханги боомт дах ажлын албанд өгөх тухай албан бичгийн дагуу төслийн талбайгаас **26 ш** хүлээлгэн өгч шийдвэрлэсэн.



Зураг 17. Аюултай хог хаягдлын дахин ашиглалт

Түүнчлэн, орон нутгийн малчин ард иргэдийн өрхийн хэрэгцээнд шаардлагатай хаягдал дугуйн дэмжлэгийг үзүүлэн ажиллалаа.



Зураг 18. Хаягдал дугуйн дахин ашиглалт

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги төслийн талбайд 2023 оны 6 сараас хойш гарсан нийт эмнэлгийн гаралтай хог хаягдлыг нэгтгэн дүгнэвэл:

№	Устгал хийсэн он сар өдөр	Хэмжих нэгж	Хэмжээ
1	2023.06.19	Грамм	618
2	2023.07.10	Грамм	334
3	2023.07.22	Грамм	538
4	2023.08.12	Грамм	2100
5	2023.08.31	Грамм	230

6	2023.09.02	Грамм	488
7	2023. 09.09	Грамм	644
8	2023.09.20	Грамм	238
9	2023.10.04	Грамм	570
10	2023.10.13	Грамм	626
11	2023.10.23	Грамм	528
12	2023.11.04	Грамм	1730
13	2023.11.	Грамм	625
14	<b>Нийт</b>	<b>Грамм</b>	<b>9.269</b>

### Хүснэгт 7. Эмнэлгийн хог хаягдлын бүртгэл

Нийт **9.3 кг** эмнэлгийн аюултай хог хаягдлыг шатаан устгасан байна.

### 6.3. Бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээ

2023 оны 04 сараас хойш нийт Ханги кемпийн хүрээнд **5** удаа Гаалийн хяналтын талбайн хүрээнд **16** удаа хог бүх нийтийн цэвэрлэгээг хийлээ. Нийтийн цэвэрлэгээг Кемпийн хашаанд дотор болон төслийн талбайн эргэн тойрон **200-300 м** хүрээ, Гаалийн хяналтын талбайн хашааны орчимд зохион байгуулсан.

№	Огноо	Оролцсон хүний тоо	Цэвэрлэсэн хог хаягдлын хэмжээ - Тон
<b>Гаалийн хяналтын талбайн бүх нийтийн цэвэрлэгээ</b>			
1	2023.03.06	24	0.8
2	2023.03.22	31	1.2
3	2023.04.02	36	1.5
4	2023.04.28	18	0.6
5	2023.05.02	19	0.7
6	2023.05.24	31	1.3
7	2023.06.05	24	1
8	2023.06.28	26	1.2
9	2023.07.06	28	0.6
10	2023.07.18	22	1.3
11	2023.08.06	17	0.4
12	2023.08.24	14	0.6
13	2023.09.10	16	0.4
14	2023.09.30	18	0.3
15	2023.10.05	22	1
16	2023.10.26	13	0.6
<b>Ханги кемпийн ажилчдын бүх нийтийн цэвэрлэгээ</b>			
1	2023.08.05	75	2 тн
2	2023.08.27	200	2тн
3	2023.09.10	30	1.5тн
4	2023.09.24	100	3тн

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

5	2023.11.26	110	4тн
---	------------	-----	-----

### Хүснэгт 8. Бүх нийтийн цэвэрлэгээний хог хаягдлын бүртгэл

Төслийн хэмжээнд бүх нийтийн хог хаягдлын цэвэрлэгээний ажлаар нийт **26 тон** ахуйн хатуу хош хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хүргэлээ.



Зураг 19. Хог хаягдлын бүх нийтийн цэвэрлэгээ

#### 6.4. Сум орон нугийн хог хаягдлын цэвэрлэгээ

Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомт хүртэлх тус аймгийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх 140 километр түр шороон зам болон баригдаж байгаа концессийн замын зочих хэсгийн Эргэл багийн нутаг дахь 140км замын хоёр талын хажуугийн 20м-ын зайд байгаа хатуу хог хаягдлыг цэвэрлэн зөөвөрлөж Хатанбулаг сумын нэгдсэн хогийн цэгт хүргэж ландфилл аргаар устгав.

2023 оны 08 дугаар сарын 27-09 сарын 12ны хооронд 22 портер, 09 сарын 10-аас 10 сарын10 хооронд 16 портер, 10 сарын 19-с 11 сарын 23 хооронд 45тн хогийг тус тус цэвэрлэн сумын төвийн хогийн цэгт хүргэж ландфилл аргаар булшилсан. Сумын төвөөс хэт алслагдсан газруудын 17 тн хогийг замын хажуугийн нүх болон кемпийн хогийн цэгүүдэд орчим хаягдлыг шатаав. Мөн замын дагуу тархсан 25 ширхэг том тэрэгний дугуй, 19 ширхэг жижиг тэрэгний дугуйг хашаа барих айлуудад тараан өгч, дахин ашиглах боломжгүй болсныг шатааж устгав.



Зураг 20. Сум орон нутгийн хог хаягдлын бүх нийтийн цэвэрлэгээ

## 7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

### 7.1. Усны хяналт, шинжилгээний дүн

Кемпийн гүний худгийн усны дээжийг “Нарт шуун консалтинг” ХХК итгэмжлэгдсэн лабораторид болон Хан Лаб лабораторт шинжлүүлсэн.

Катион	1 дм <sup>3</sup>			Анион	1 дм <sup>3</sup>		
	Мг/л	Мг-экв/л	Мг-экв%		Мг/л	Мг-экв/л	Мг-экв%
Ca <sup>++</sup>	169.00	8.43	17.98	CO <sub>3</sub> <sup>-</sup>	0.00	0.00	0.00
Mg <sup>++</sup>	164.00	13.49	28.76	HCO <sub>3</sub> <sup>-</sup>	330.00	5.41	11.53
Fe	0.00	0.00	0.00	Cl <sup>-</sup>	69.00	1.95	4.15
K <sup>+</sup>	9.00	0.23	0.49	SO <sub>4</sub> <sup>-</sup>	1843.00	38.40	81.85
Na <sup>+</sup>	569.00	24.75	52.76	NO <sub>3</sub> <sup>-</sup>	72.0	1.16	2.48
Дүн	911.00	46.91	100.00	Дүн	2314.00	46.91	100.00

Хүснэгт 9. Усны химийн шинжилгээний үр дүн

№	Ус	Нянгийн тоо	Гэдэсний савханцарын титр (E.coli)	Анаэробын (Cl.perfringens)
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу
1	НАБТ	2	Илрээгүй	Илрээгүй

Хүснэгт 10. Усны нян судлалын шинжилгээний үр дүн

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН




График 1. Ханги кемпийн худгийн усны химийн шинжилгээний харьцуулалт

Ханги ажилчдын хотхоны усны шинжилгээний дүн:

№	ЭЛЕМЕНТ	НЭГ Ж	ШИНЖИЛ ГЭЭНИЙ ДҮН 2023.03.06	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН 2023.06.23		ШИНЖИЛ ГЭЭНИЙ ДҮН 2023.10.06		ЗӨВШӨӨ РӨГДӨХ ДЭД	СТАНДАРТ АРГА
			Гал тогооны усны дээж	Боомтын гүний худаг	Кемпийн гүний худаг	Боомтын гүний худаг	Кемпийн зүүн худаг		
1	pH	-	8.00	7.78	7.21	8.44	8.39	6.5-8.5	MNS ISO 10523:2001
2	Кали (K <sup>+</sup> )	мг/л	1.01	0.71	8.93	0.52	0.44		MNS 5465:2005
3	Натри (Na <sup>+</sup> )	мг/л	256.2	186.2	2410	183.5	177.4	200.0	
4	Кальци(Ca <sup>2+</sup> )	мг/л	38.51	23.94	294.6	11.77	21.41	100.0	MNS ISO 2572-1999
5	Магни (Mg <sup>2+</sup> )	мг/л	20.87	27.71	316.1	10.75	26.86	30.0	
6	Аммоний (NH <sub>4</sub> <sup>+</sup> )	мг/л	<0.10	<0.10	0.2	<0.10	<0.10	1.50	MNS ISO 7150-1:2006
7	Хлорид (Cl <sup>-</sup> )	мг/л	195.7	160	3308	66.36	86.78	350.00	MNS ISO 9297:2005
8	Сульфат(SO <sub>4</sub> <sup>2-</sup> )	мг/л	137.8	193.1	2448	98.78	160.5	500.00	MNS 3652.4:1984
9	Нитрит (NO <sub>2</sub> )	мг/л	0.05	0.06	0.08	<0.05	<0.05	1.00	MNS 4431:2005
10	Нитрат (NO <sub>3</sub> )	мг/л	0.66	1.64	2.06	3.99	3.81	50.00	MNS ISO 7890-3:2001
11	Карбонат(CO <sub>3</sub> <sup>2-</sup> )	мг/л	7.50	3	<1.50	7.5	<1.50	-	MNS ISO 9963-1:2005
12	Гидрокарбонат (HCO <sub>3</sub> <sup>-</sup> )	мг/л	392.5	250.2	256.3	326.4	344.7	-	
13	Нийт хатуулаг	мг/эк в/л	3.64	3.48	40.72	1.47	3.28	7.00	
14	Хуурай үлдэгдэлTDS	мг/л	870.0	742	9012	564	669	-	
15	Цахиурын хүчил(H <sub>2</sub> SiO <sub>3</sub> )	мг/л	8.95	11.47	9.56	13.03	12.42	-	
16	Исэлдэх чадвар(KMnO <sub>4</sub> )	мгO <sub>2</sub> /л	4.80	6.24	18.52	2.32	2.56	-	MNS ISO 4889:1999
17	Фосфат (PO <sub>4</sub> <sup>3-</sup> )	мг/л	<0.05	<0.5	<0.05	<0.05	<0.05	3.50	MNS ISO 6878:2001
18	Фтор(F)	мг/л	0.71	1.46	6.14	3.04	2.72	0.7-1.5	MNS ISO 10359-1:2002
19	Хүхэрт устөрөгч(H <sub>2</sub> S)	мг/л	<0.10	<0.10	<0.10	<0.10	<0.10	0.10	
20	Чөлөөт хлорид (Cl)	мг/л	<0.10	<0.10	<0.10	<0.10	<0.10	0.2-0.3	MNS ISO 7393-1:2001
21	Булингар	ntu	<10.0	<10.0	<10.0	<10.0	<10.0	1.50	
22	Мөнгө (Ag)	мг/л	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.70	
23	Хөнгөнцагаан(Al)	мг/л	<0.025	<0.025	<0.025	<0.025	<0.025	0.50	
24	Мышьяк (As)	мг/л	0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.01	
25	Бор (B)	мг/л	1.28	0.86	3.53	1.49	1.14	2.40	

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



26	Барн (Ba)	мг/л	<0.01	0.02	<0.01	0.03	0.02	0.70	
27	Беррели (Be)	мг/л	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001	0.002	
28	Кадми (Cd)	мг/л	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	0.003	
29	Кобальт (Co)	мг/л	<0.001	0.001	<0.001	0.001	0.002	-	
30	Хром (Cr)	мг/л	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	0.05	
31	Зэс (Cu)	мг/л	<0.02	<0.02	<0.02	<0.02	<0.02	2.00	MNS (ISO) 11885:2001
32	Төмөр (Fe)	мг/л	<0.03	<0.03	0.36	<0.03	<0.03	0.30	
33	Марганец (Mn)	мг/л	<0.01	<0.01	0.06	<0.01	<0.01	0.10	
34	Молибден (Mo)	мг/л	0.02	<0.005	<0.005	0.01	0.07	0.07	
35	Никель (Ni)	мг/л	<0.005	<0.005	<0.005	<0.005	<0.005	0.02	
36	Хартугалга (Pb)	мг/л	<0.01	<0.01	<0.01	0.01	<0.01	0.01	
37	Сурма (Sb)	мг/л	<0.01	<0.01	0.01	<0.01	<0.01	0.02	
38	Селен (Se)	мг/л	<0.05	<0.05	<0.05	<0.01	<0.01	0.04	
39	Стронци (Sr)	мг/л	1.27	0.72	9.76	0.53	0.72	2.00	
40	Уран (U)	мг/л	<0.10	<0.10	<0.10	<0.10	<0.10	0.03	
41	Цайр (Zn)	мг/л	0.03	<0.01	0.7	<0.01	<0.01	5.00	
42	Цианид (CN <sub>free</sub> )	мг/л	<0.002	<0.002	<0.002	<0.002	<0.002	0.01	
43	Мөнгөн ус (Hg)	мг/л	<0.001	<0.001	<0.001	<0.001	<0.001	0.001	
									Стандартаас давсан үзүүлэлтийг өнгөөр тэмдэглэв

### Хүснэгт 11. Ханги ажилчдын хотхоны усны химийн шинжилгээний үр дүн

Ус зүйн шинжилгээ Гаалийн хяналтын талбай, Ханги ажилчдын хотхон орчмын уснаас сульфат 1343 мг/л, натри 369 мг/л, магни 134 мг/г, кальцийн 69 мг/г хэмжээ тус бүр Монгол улсын ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын MNS0900:2018- стандартын зөвшөөрөгдөх дээд стандартаас хэтэрсэн ба эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байгаа тул ахуйн хэрэглээнд хэрэглэвэл аюулгүй болно. Химийн бүрэлдэхүүнээрээ: Сульфатын анги, натрийн бүлэг, 3 төрлийн давстай буюу шорвогдуу, маш хатуу ус бөгөөд зайлшгүй унданд хэрэглэх тохиолдолд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.

Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно.

Ундны ус хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж, эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

## 7.2. Хөрсний бохирдлын хяналт шинжилгээний дүн

Гаалийн хяналтын талбайн хөрсний шинжилгээний нэгдсэн дүн:

№	Лаб №	Гүн, см	рН	Давс %	Cond, dsm	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> Mg/100г	Солил цох суурь, мг-экв/100гр		Шим тэжээлийн элементүүд мг/100гр	
									Ca <sup>+2</sup>	Mg	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Дээж-1/N 42°42'27.9" E 109°57'24.7"/												
1	23/12-22/11	0-20	8.70	0.126	0.295	1.48	0.64	0.69	13	9	3.0	20
Дээж-2/N 42°42'27.4" E 109°57'25.0"/												
2	23/12-22/2	0-20	8.60	0.517	1.216	1.72	0.32	1.16	16	13	3.0	18
Дээж-3/N 42°42'47.7" E 109°56'56.0"/												
3	23/12-22/3	0-20	8.97	0.033	0.078	1.01	0.0	0.29	9	5	2.2	14
Дээж-4/N 42°42'43.7" E 109°57'26.3"/												
4	23/11-30/3	0-20	8.37	0.035	0.082	1.05	2.24	0.24	10	14	1.9	16






Хүснэгт 12. Гаалийн хяналтын талбайн хөрсний шинжилгээний үр дүн



График 2. Гаалийн хяналтын талбайн урвалын орчин болон ялзмагийн хэмжээ

Гаалийн хяналтын талбай орчмын талбайгаас 0-20 см гүнд хөрсний дээж авахад талбайн орчимд цөлөрхөг хээрийн /ердийн/ бор хөрс тархсан. Хөрсний тархалтаар урвалын орчин нь/РН/ 8.37-8,97 ба хамгийн түгээмэл тархсан маш хүчтэй шүлтлэгийн орчинтой. Шүлтлэг хөрсүүд суурь катионуудаар (K<sup>+</sup>, Ca<sup>2+</sup>, Mg<sup>2+</sup> and Na<sup>+</sup>) ханасан байдал өндөртэй . Ийм хөрсүүдийг уусах давсын агууламжаар нь бага зэргийн давжилттай, цахилгаан дамжуулах чанар багтай шүлтлэг хөрс юм. Шүлтлэг хөрсүүд карбонатуудыг агуулдаг.

Качинскийн ангиллаар хөрсний механик бүрэлдэхүүний хувьд шавар, физик элс 2 харьцаагаар, 0.01мм-ээс бага диаметртай физик шаврын хэмжээгээр элс, шавранцар, лаг ба дээжүүдийн ихэнх хэсэг нь элсэрхэг механик бүрэлдэхүүнтэйг илтгэх бөгөөд элсэрхэг элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нэлээд их талбай эзэлж байна.



Гаалийн хяналтын талбай орчмын хөрснөөс авсан 4 дээжийн хүнд металлын шинжилгээ нь 6 төрлийн химийн хүнд металл болох никель, кадми, хар тугалга, цайр, хром болон зэс нь MNS5850:2019 стандартын элсэрхэг хөрсөнд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй тул бохирдолгүй болно.

График 3. Гаалийн хяналтын талбайн хүнд элементийн бохирдлын төвшин

**Ханги кемпийн хөрсний шинжилгээний нэгдсэн дүн:**

№	ЭЛЕМЕНТ, Т, мг/кг	2023.04.04		2023.06.27		2023.10.06		Стандарт  MNS5850:2019
		Кемп дотор	Засварын талбай	Кемпийн амрах байр, Оффисын орчим	Засварын талбайн орчим	Кемпийн амрах байр орчим 42.70595N , 103.95585E	Засварын талбайн орчим 42.7803N, 109.95797E	
		Илэрсэн хэмжээ	Илэрсэн хэмжээ	Илэрсэн хэмжээ	Илэрсэн хэмжээ	Илэрсэн хэмжээ	Илэрсэн хэмжээ	
1	<b>Na</b>	1.55	1.40	1.19	1.19	0.99	1.20	-
2	<b>Ca</b>	1.53	1.21	1.04	1.17	1.26	1.10	-
3	<b>Mg</b>	0.67	0.54	0.47	0.46	0.84	0.60	-
4	<b>K</b>	1.84	1.60	1.55	1.55	1.96	1.79	-
5	<b>Фенийт</b>	2.80	2.22	1.69	1.86	2.58	1.68	-
6	<b>As</b>	6.94	10.73	12.21	13.04	12.87	10.17	20.00
7	<b>Ba*</b>	481.3	445.1	424.5	426.8	429.1	439.2	-
8	<b>Be</b>	<1.0	<1.0	<5.0	<5.0	1.07	<1.0	-
9	<b>Bi</b>	<10.0	<10.0	<10.0	<10.0	<10.0	<10.0	-
10	<b>Cd</b>	<1.0	<1.0	<1.0	<1.0	<1.0	<1.0	3.00
11	<b>Co</b>	10.06	10.80	9.16	9.77	10.79	7.58	50.00
12	<b>Cr</b>	57.32	60.91	50.38	41.37	56.60	34.23	150.0
13	<b>Cu</b>	13.03	11.01	10.71	6.35	15.71	11.84	100.0

**Хүснэгт 13. Ханги кемпийн талбайн хөрсний шинжилгээний үр дүн**

2023 онд хийгдсэн хөрсний шинжилгээ нь хөрсний химийн бодисыг тодорхойлж, хүнд металл, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон байдлыг шалгаж үзэх зорилготойгоор холимог дээжийн судалгааг 28 элементийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Шинжилгээний дүнгээс харахад МУ-ын MNS5850:2019 стандарт болон статистик тоо хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй нь тус төслийн талбайд хийгдэж байгаа засвар үйлчилгээ нь асгаралт шатах тослох материалын дүрэм журмыг сахин ажиллаж байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

## 8. УДИРДАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- Тухайн төслийн 2023 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөө нийт 13 бүлэг 98 заалттайгаар БОАЖЯ-ны ХБОБЗГ-аар 2023 оны 7-р сарын 20-ны өдөр батлагдсан.
- БОАЖС-ын 2021 оны 7-р сарын 9-ний өдрийн 01/3144 дугаар бүхий ай савын лавлагаатай.
- Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 5-р сарын 24-ний өдрийн 253 дугаар бүхий Ус ашиглуулах дүгнэлттэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын 2023 оны 6-р сарын 29-ний өдрийн А/126 дугаар бүхий Ус ашиглуулах зөвшөөрөлтэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны 6-р сарын 29-ний өдрийн Ус ашиглуулах гэрээтэй.
- Галба-Өөш-Долоодын сав газрын 2023 оны 4-р сарын 03-ны өдрийн 2023/01 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэг тогтоох дүгнэлттэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргын 2023 оны 10-р сарын 4-ний өдрийн А/172 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэгийн зөвшөөрөлтэй.
- 2023 оны 1-р сарын 23-ны өдөр баталгаажсан LXLG-40 загварын 16м3/ц хэмжилтийн хязгаартай, 40 мм голчтой, 202000311 дугаартай, 047 дугаар бүхий лацтай тоолуурыг 2023 оны 1-р сарын 26-ны өдөр суурилуулсан.
- Төслийн хэмжээнд дагаж мөрдөх шаардлагатай 23 байгаль орчны журмын жагсаалтыг тодорхойлсон.
- Байгаль орчны хөндлөнгийн аудитыг “Мон газар консалтинг” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд холбогдох тайлан, зөвлөмж ирээгүй байна.
- БОМТ-2023 нийт төсөв **84.9 сая**.
- Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг төслийн дотоод орчинд ажилчдын дунд зохион байгуулан ажиллалаа.

### **“Уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай ажлын тайлан**

Уур амьсгалын өөрчлөлт нь хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөтэй хавсран биологийн олон янз байдлын хомсдол, газрын доройтол, цөлжилтийн явцыг түргэтгэж байна.

НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлт болон Биологийн олон янз байдлын тухай конвенцийн хүрээнд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, биологийн олон янз байдлын хомсдолыг бууруулах талаар Монгол Улсаас авч хэрэгжүүлж байгаа бодлого, санал, санаачилга, үйл ажиллагааны чиглэлд хүн бүрийноролцоо чухал билээ.

Энэ чиглэлийн дагуу уур амьсгалын элементүүдийн өнөө болон ирээдүйн өөрчлөлтийн байгаль, нийгэм-эдийн засгийн салбарт шууд болон дам байдлаар нөлөөлөх бөгөөд тэдгээрийг салбаруудын хувьд нэгдсэн байдлаар өнөөгийн өөрчлөлт, нөлөөлөл болон ирээдүйн нөлөөлөл, эмзэг байдал, эрсдлийг салбар тус бүрээр ангилан богино хэмжээний танилцуулга бэлтгэн Засварын хэлтэсийн адрийн ба шөнийн ээлжний 41 ажилтанд сургалт орлоо.



Зураг 21. Уур амьсгалын сургалт

## 9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТГИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой асуудлаар удирдлагын багаас төрийн байгууллагууд болон орон нутгийн малчин ард иргэдэд мэдээлэл өгч ажиллалаа.

## 10. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 2023 БИЕЛЭЛТИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1. “Тавантолгой-Манлай-Ханги” чиглэлийн хатуу хучилттай авто зам барих төслийн 2023 оны БОМТ 13 бүлэг, 98 заалттай боловсруулагдсан.
2. БОМТ-2023 бодит хэрэгжилт **92.7 %** байна.
3. БОМТ-2023-ийг 4 байгаль орчны мэргэжилтний дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн.
4. БОМТ-2023 нийт батлагдсан зардал **84.9 сая** төгрөг. Бодит зарцуулалт: **49 сая** бөгөөд үлдсэн төлбөрүүд 2024 оны 05-р сарын 1-нд зарцуулагдана.
5. БОМТ-2023-т багтсан 3 ажлын гэрээг 2023 оны 5-р сарын 15-ний өдрийг хүртэл сунгав.
6. Төсөлд шаардлагатай **23** дотоод журмын жагсаалтыг гарган баталсан.

### Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн дүгнэлт

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Агаар орчныг хамгаалах чиглэлд 7 заалт бүхий ажлыг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

#### Үүнд:

- Нүүрс тээврийн богино болон холын тээвэрт явах хөдөлгөөнт техникийн замын хөдөлгөөний дүрмийг гаргаж, нийт жолооч нарт зааварласан.
- Нүүрс тээврийн ачиж буулгах талбай болон авто жингийн хэсгүүдэд хурдны хязгаар болон бусад үамын хөдөлгөөний анхааруулах тэмдгүүдийг байршуулж өгсөн.

- Нүүрс тээврийн технологийн замын тоосжилтын төвшинг бууруулах зорилгоор өдөр болон шөнийн ээлжинд замын усалгааг тогтмол гүйцэтгэсэн бөгөөд 2023 оны туршид нийт **2880 тонн** усыг нарийн ширхэгтэй тоосжилт дарахад ашигласан байна.
- Нүүрс тээвэрлэх, ачиж буулгах үйл ажиллагааг цаг агаарын нөхцөлтэй уялдуулан гүйцэтгэж ажилласан бөгөөд шаардлагатай цаг агаарын сэрэмжтэй нөхцөлд төслий үйл ажиллагааг тодорхой хугацаатай зогсоон ажиллалаа.
- Агаарын нарийн ширхэгт тоосонцорын хэмжилт, дуу чимээ, дэгдэмхий бодисын хэмжээ болон формальдгидийн хэмээг гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхон дотор сар бүр гүйцэтгэсэн бөгөөд уртын болон богинын тээвэртэй, тээвэргүй үед хяналтын цэгт хэмжсэн.

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Усны нөөц болон чанарыг хамгаалах чиглэлд 11 заалт бүхий ажлыг **90%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

#### Үүнд:

Төслийн хувьд ус ашиглалтын байдалд хууль эрхзүйн дараах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа.

- БОАЖС-ын 2021 оны 7-р сарын 9-ний өдрийн 01/3144 дугаар бүхий ай савын лавлагаатай.
- Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 5-р сарын 24-ний өдрийн 253 дугаар бүхий Ус ашиглуулах дүгнэлттэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын 2023 оны 6-р сарын 29-ний өдрийн А/126 дугаар бүхий Ус ашиглуулах зөвшөөрөлтэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны 6-р сарын 29-ний өдрийн Ус ашиглуулах гэрээтэй.
- Галба-Өөш-Долоодын сав газрын 2023 оны 4-р сарын 03-ны өдрийн 2023/01 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэг тогтоох дүгнэлттэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргын 2023 оны 10-р сарын 4-ний өдрийн А/172 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэгийн зөвшөөрөлтэй.
- 2023 оны 1-р сарын 23-ны өдөр баталгаажсан LXLG-40 загварын 16м<sup>3</sup>/ц хэмжилтийн хязгаартай, 40 мм голчтой, 202000311 дугаартай, 047 дугаар бүхий лацтай тоолуурыг 2023 оны 1-р сарын 26-ны өдөр суурилуулсан.
- **Гаалийн хяналтын талбайн худгийн хувьд:** Ус зүйн шинжилгээ НАБТ орчмын уснаас сульфат 1343 мг/л, натри 369 мг/л, магни 134 мг/г, кальцийн 69 мг/г хэмжээ тус бүр Монгол улсын ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын MNS0900:2018- стандартын зөвшөөрөгдөх дээд стандартаас хэтэрсэн ба эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байгаа тул ахуйн хэрэглээнд хэрэглэвэл аюултай болно. Химийн бүрэлдэхүүнээрээ: Сульфатын анги, натрийн бүлэг, 3 төрлийн давстай буюу шорвогдуу, маш хатуу ус бөгөөд зайлшгүй унданд хэрэглэх тохиолдолд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.
- **Боомтын худгийн хувьд:** 2023 оны цэвэр усны шинжилгээний хариунаас дүгнэхэд Ханги төслийн талбайн ажилчдын ундны усны эх үүсвэр болох “Боомтын худаг”-ийн хариу нь Монгол Улсын MNS 0900:2018 стандартын хэмжээнд байгаа боловч энэ бүс нутгийн усны рН **7,21-8,44** байгаа үзүүлэлт нь шүлтлэг чанар өндөртэй болохыг харуулж байна.
- Мөн Уран, Селен, Никель Кадми, Берелли зэрэг хүнд элементийн үзүүлэлт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс илүү байна.

- Тус бүс нутгийн эрдэсжилт өндөртэй усыг хүнсэнд хэрэглэх үед биеийн ерөнхий тав тух алдагдах, ам цангах, биеийн хүчил шүлтийн тэнцвэр өөрчлөгдөх, зүрхний ажиллагаа сулрах, ходоод гэдэсний архаг зарим өвчин хурцдах зэрэг шинж тэмдгүүд илэрнэ.
- Мөн эмч нарын үзэж байгаагаар цусны эргэлтийн тогтолцооны өвчнүүд /ЦЭТӨ/ тухайлбал цусны даралт ихсэх, зүрхний шигдээс, атеросклероз /судас хатуурах/, хоол боловсруулах эрхтний өвчнүүд /ХБЭӨ/ тухайлбал ходоод, нарийн бүдүүн гэдэсний үрэвсэлт өвчнүүд, элэг цөсний архаг өвчин мөн бөөр шээсний замын чулуужих өвчин /БШЗЧӨ/ зэрэг нь эрдэсжилтээс шалтгаалах өвчин эмгэгт хамаардаг байна.
- Иймд катионитон шүүлтүүр бүхий ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж усыг цэнгэгжүүлэн зөөлрүүлж ашиглах, буцалгаж хэрэглэх нь эрүүл мэндэд чухал ач холбогдолтой.
- Нийт ашиглах усны хэмжээ : **4122.5м3**, Унд ахуйн хэрэгцээнд : **1020.0м3**, Зам талбайн тоосжилт дарах зориулалтаар : **3102.5м3** ус ашиглахаар төлөвлөгдсөн. Нийт ашигласан ус: **4530 м3**
- Ханги кемпийн “Ажилчдын байр, автобааз, гаалийн хяналтын талбайг” төслийн ажилчдын хэрэглээний усаар хангадаг LXLG-10 тоолууртай гүний худаг ашигладаг. Тус худгийн тоолуурыг стандарт хэмжилзүйн лабораториор баталгаажуулан үйл ажиллагаанд хэрэглэж байна. 2023 оны тоолуурын заалтад тулгуурлан төлбөрийг сумын татварын алба тооцож, нэхэмжлэх гаргуулан нэхэмжлэлийн дагуу ус ашигласны төлбөрт **1 сая** төгрөгийг төлж барагдуулсан.

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – Хөрс хамгаалах чиглэлд 13 заалт бүхий ажлыг **80%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

#### Үүнд:

- Хөрсний агрохимийн 1 дээжийг 300-500 гр, хүнд металлын 1 дээжийг 200-300 гр хэмжээтэй, эрүүл ахуйн 1 дээжийг 300-500 гр хэмжээтэй тус бүр авсан.
- Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн дагуух Гаалийн хяналтын талбай нь Дорноговь аймгийн Хатанбулаг суманд байрлах бөгөөд цөлөрхөг хээрийн хужирлаг бор хөрстэй. Хөрсний онцлог нь хөрсний бүх давхаргад хатхаараа гялтганаж харагдах. Хөрсний үржил шимт үе давхаргын ялзмагийн агууламж 1.05-1.45%, хөдөлгөөнт кали 16-20 мг/100гр, хөдөлгөөнт фосфор 1.9-3 мг/100гр байгаа нь хөрсний үржил шимийн түвшин бага байгааг илтгэх бөгөөд карбонатын (CaCO<sub>3</sub> %) агууламж 0.-2.24 %, ууссан хүчилтөрөгч (pH) 8.37-8.70 хөрсний үржил шимийн түвшин говийн хөрсөндөөдунд зэргийн үзүүлэлт боловч хялбар уусах давсны агууламж өндөр, шүлтлэг урвалын орчинтой учир ургамалд хаалт үүсгэх гол шалтгаан юм.
- Гаалийн хяналтын талбай орчмын хөрсний хүнд металлын шинжилгээгээр 6 төрлийн химийн хүндметалл болох никель, кадми, хар тугалга, цайр, хром болон зэс нь MNS5850:2019 стандартын элсэрхэг хөрсөнд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй тул бохирдолгүй.
- Асгаралтын тухай ажилчдад чиглүүлэх сургалтыг ХЭМАБО хэлтсээс зохион байгуулж, сургалтанд Засварын хэлтсийн **15** ажилтан, Тээврийн хэлтсийн **27** ажилтан хамрагдав. Сургалтын гол чиглэл шатах тослох материал гэж юу вэ, нэр томъёо, хуулийн зүйл заалтууд, асгаралтын сөрөг үр дагавар, асгаралтын үед авах арга хэмжээг хэрхэн үр дүнтэй менежменттэй зохион байгуулах, асгаралтын мэдээлэх нь байгаль орчиндоо хайртай иргэн бүрийн хувь нэмэр гэсэн агуулгын хүрээнд удирдан зохион байгуулав. Мөн асгаралтыг хянах газрын тосны гаралтай болон бусад синтезийн гаралтай химийн



бодисоор бохирдсон хөрс усыг хэрхэн цэвэрлэх, асгаралтын иж бүрдлийг хэрхэн зөв ашиглах зэрэг сэдвийн хүрээнд сургалтыг явууллаа.

- 2023 онд нийт дизель түлшний асгаралт – **49 литр**, хурдны хайрцагны тос – **18 литр**, гидрийн шингэн – **42 литр**, тосоор бохирдсон материал – **33 кг** үүссэн ба нийт гадаргын идэвхит нийллэг бүтээгдэхүүний бохирдлыг хөрс саармагжуулах талбайд хураан элс, ахуйн үнс, модны үртэс зэргээр саармагжууллаа.

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – газар, түүний хэвлийг хамгаалах чиглэлд 3 заалт бүхий ажлыг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

#### Үүнд:

- Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бүхий хэсгийн газрууд холбогдох зөвшөөрлийн хүрээнд зориулалтын дагуу ашиглагдаж байна. Холбогдох төлбөрүүд Хатанбулаг сумын татварын албанд төлөгдөж байна.
- Аливаа төслийн бүтээн байгуулалтын үед шинээр газар хөндөхөөр бол байгаль орчны багаас урдчилан зөвшөөрөл авна.

Төслөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд – биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлд 7 заалт бүхий ажлыг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

#### Үүнд:

- Амьтны мониторинг судалгааг сар бүр нийт **10** удаагийн давтамжтай өдөр болон шөнийн цагт Ханги ажилчдын хотхон болон гаалийн хяналтын талбайд дараах амьтдын төрөл зүйл бүртгэгдсэн.

Гаалийн хяналтын ашиглалтын үйл ажиллагааны талбайд дараах амьтад бүртгэгдэв.

- ξ Хонин гүрвэл
- ξ Цоохор гүрвэл
- ξ Хар хорхой
- ξ Алагдаахай
- ξ Талын жиргэмэл шувуу
- ξ Хотны бүгээхэй шувуу
- ξ Хон хэрээ зэрэг амьтад өдөр шөнийн цагт бүртгэгдэв.

Ханги ажилчдын хотхоны ойр орчимд дараах төрлийн амьтад бүртгэгдсэн.

- ξ Хонин гүрвэл
- ξ Цоохор гүрвэл
- ξ Хар хорхой
- ξ Алагдаахай
- ξ Дэлдэн зараа
- ξ Молтогчин туулай
- ξ 3 зүйл могой
- ξ Хон хэрээ зэрэг амьтад өдөр шөнийн цагт бүртгэгдэв.
- Ургамлын монитоинг судалгааг улирал тутамд нийт **4** удаа Ханги ажилчдын хотхон болон гаалийн хяналтын талбайд гүйцэтгэсэн бөгөөд дараах **5** төрлийн ургамлууд бүртгэгдсэн.

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

- Байгалийн ургамлын тухай хуулийн 15.2, 16.1, 17.3 хэсэгт дэлгэрэнгүй заасанчлан байгалийн ховор, нэн ховор ургамлыг зөвшөөрөлгүйгээр түүж бэлтгэхийг хориглох тухай заалтыг төслийн талбайд ажиллаж буй ажилчдад танилцуулан, холбогдох зурагт постерийг хэвлэн, шаардлагатай газруудад байршууллаа.

Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн чиглэлд 2 заалт бүхий ажлыг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

**Үүнд:**

- Гаалийн хяналтын талбайд нийт сухай – 25 ш, Хайлаас – 15 ш тус тус
- Ханги ажилчдын хотхонд 2023 оны 10 сарын 31-11 сарын 6 өдөр хүртэл 100 ширхэг хайлаас, 25 ширхэг нарсны суулгацыг кемпийн хашаанд тарилаа.
- Ургалт болон өвөлжилтийн байдал 80%.

Түүх соёлын өвийг хамгаалах чиглэлд төлөвлөл байхгүй байсан хэдий ч Түүх, соёлын өвтэй холбоотой зурагт постеруудыг бэлтгэн шаардлагатай газруудад байршуулсан.

**Үүнд:**

- “Тахилт хайрхан транс” ХХК-ийн байгаль орчны албанаас түүх соёлын өвийг хамгаалах ажлыг сурталчлан таниулах, соёлын биет өв олдвол ажлаа зогсоож, байгаль орчны багт мэдээллийг хүргэх, авран хамгаалах зэрэг ажлыг нийт гэрээлэгчдэд танилцуулсан.

Осол эрсдэлийн менежментийн ажлын биелэлтийг **100%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

**Үүнд:**

- Байгаль орчны багийн дотоод ажлын байрны үзлэгийг 2023 оны 4-р сараас эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд Гаалийн хяналтын талбай болон Ханги ажилчдын хотхоны дотоод болон гадаад орчинд нийт **10 удаа** хийж гүйцэтгэсэн. Үзлэгээр байгаль орчны ижил төрлийн нийт **36** зөрчил, дутагдлыг илрүүлж холбогдох хэсгийн удирдах ажилтанд илгээж, сайжруулалтуудыг гүйцэтгүүлэн.
- Байгаль орчны баг болон хэлтэс нэгжүүдийн удирдах ажилчид, хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэнгүүдтэй хамтарсан байгаль орчны хууль эрхзүйн нийцэлд үнэлгээ өгөх, орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор нийт **4** удаагийн дотоод аудитыг гүйцэтгэж, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.
- 2023 онд байгаль орчны зөрчил бүртгэгдээгүй

Хог хаягдлын менежментийн чиглэлд 11 заалт бүхий ажлыг **90%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

**Үүнд:**

- 2023 оны туршид нийт төслийн хэмжээнд хатуу болон ландфиллийн хог хаягдал **1253** тоныг Хатанбулаг сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргүүлсэн.
- Нийт **39** тон хоолны хог хаягдал болон **114** тон ахуйн үнсний хаягдлыг өөрсдийн хог хаягдлын цэгт ландфил аргаар булшилсан.
- Нийт **8210** тон ахуйн саарал усыг бохир ус хаях зөвшөөрөлтэй цэгтээ хаясан.
- Нийт **2500 ш** хуванцар савыг “Чингүүн Марал” ХХК-д хүлээлгэн өгсөн.
- Нийт **6** тон орчим хог хаягдлыг Заагийн хогийн цэгт тус тус хаясан байна.

- Хатанбулаг сумын ЗДТГ-тай байгуулсан 2023 оны 1-р сарын 23-ны өдрийн Хог хаягдлын гэрээгээр төлбөр **600.000** төгрөг бөгөөд тухайн төлбөрийг барагдуулсан. Түүнчлэн, хог ачилтын төлбөрт нийт **44.330.000** төгрөгийг тус тус төлсөн байна.
- Нийт төслийн хэмжээнд ажилласан тос масло – **10 тон**, хаягдал дугуй – **128 ш**, хаягдал аккумулятор – **37 ш**, тос маслын шүүр – **42 ш**, тос тосолгооны хоосон сав-**160 ш**, тосоор бохирдсон материал – **0,8 тон** орчим байна.
- Хатанбулаг сумын засаг даргын 2023 оны 9-р сарын 12-ны өдрийн **01/706** тоот албан хүсэлтийн дагуу **250 ш** хаягдал дугуйг Ханги боомт дах ажлын албанд өгөх тухай албан бичгийн дагуу төслийн талбайгаас **26 ш** хүлээлгэн өгч шийдвэрлэсэн.
- Түүнчлэн, орон нутгийн малчин ард иргэдийн өрхийн хэрэгцээнд шаардлагатай хаягдал дугуйн дэмжлэгийг үзүүлэн ажиллалаа.
- Нийт **9.3 кг** эмнэлгийн аюултай хог хаягдлыг шатаан устгасан байна.
- 2023 оны 04 сараас хойш нийт Ханги кемпийн хүрээнд **5** удаа Гаалийн хяналтын талбайн хүрээнд **16** удаа хог бүх нийтийн цэвэрлэгээг хийлээ. Нийтийн цэвэрлэгээг Кемпийн хашаанд дотор болон төслийн талбайн эргэн тойрон **200-300 м** хүрээ, Гаалийн хяналтын талбайн хашааны орчимд зохион байгуулсан.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомт хүртэлх тус аймгийн нутаг дэвсгэрийг дайран өнгөрөх 140 километр түр шороон зам болон баригдаж байгаа концессийн замын зочих хэсгийн Эргэл багийн нутаг дахь 140км замын хоёр талын хажуугийн 20м-ын зайд байгаа хатуу хог хаягдлыг цэвэрлэн зөөвөрлөж Хатанбулаг сумын нэгдсэн хогийн цэгт хүргэж ландфилл аргаар устгав.
- 2023 оны 08 дугаар сарын 27-09 сарын 12ны хооронд 22 портер, 09 сарын 10-аас 10 сарын 10 хооронд 16 портер, 10 сарын 19-с 11 сарын 23 хооронд 45тн хогийг тус тус цэвэрлэн сумын төвийн хогийн цэгт хүргэж ландфилл аргаар булшилсан. Сумын төвөөс хэт алслагдсан газруудын 17 тн хогийг замын хажуугийн нүх болон кемпийн хогийн цэгүүдэд орчим хаягдлыг шатаав. Мөн замын дагуу тархсан 25 ширхэг том тэрэгний дугуй, 19 ширхэг жижиг тэрэгний дугуйг хашаа барих айлуудад тараан өгч, дахин ашиглах боломжгүй болсныг шатааж устгав.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын чиглэлд 4 заалт бүхий ажлыг **80%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

- Ус зүйн шинжилгээ Гаалийн хяналтын талбай, Ханги ажилчдын хотхон орчмын уснаас сульфат 1343 мг/л, натри 369 мг/л, магни 134 мг/г, кальцийн 69 мг/г хэмжээ тус бүр Монгол улсын ундны ус эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын MNS0900:2018-стандартын зөвшөөрөгдөх дээд стандартаас хэтэрсэн ба эрүүл ахуй, чанар аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй байгаа тул ахуйн хэрэглээнд хэрэглэвэл аюулгүй болно. Химийн бүрэлдэхүүнээрээ: Сульфатын анги, натрийн бүлэг, 3 төрлийн давстай буюу шорвогдуу, маш хатуу ус бөгөөд зайлшгүй унданд хэрэглэх тохиолдолд цэнгэгжүүлж, зөөлрүүлж хэрэглэх шаардлагатай.
- Усны нөөцийг хомсдох, бохирдохоос хамгаалах, үер, усны гамшгаас сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, усны эх үүсвэрт онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс тогтооно.
- Ундны ус хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж, эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

- Гаалийн хяналтын талбай орчмын талбайгаас 0-20 см гүнд хөрсний дээж авахад талбайн орчимд цөлөрхөг хээрийн /ердийн/ бор хөрс тархсан. Хөрсний тархалтаар урвалын орчин нь/РН/ 8.37-8,97 ба хамгийн түгээмэл тархсан маш хүчтэй шүлтлэгийн орчинтой. Шүлтлэг хөрсүүд суурь катионуудаар (K+, Ca<sup>2+</sup>, Mg<sup>2+</sup> and Na<sup>+</sup>) ханасан байдал өндөртэй . Ийм хөрсүүдийг уусах давсын агууламжаар нь бага зэргийн давсжилттай, цахилгаан дамжуулах чанар багтай шүлтлэг хөрс юм. Шүлтлэг хөрсүүд карбонатуудыг агуулдаг.
- Качинскийн ангиллаар хөрсний механик бүрэлдэхүүний хувьд шавар, физик элс 2 харьцаагаар, 0.01мм-ээс бага диаметртэй физик шаврын хэмжээгээр элс, шавранцар, лаг ба дээжүүдийн ихэнх хэсэг нь элсэрхэг механик бүрэлдэхүүнтэйг илтгэх бөгөөд элсэрхэг элэгдэл эвдрэлд амархан өртөмтгий сийрэг элсэн хөрс нэлээд их талбай эзэлж байна.
- Гаалийн хяналтын талбай орчмын хөрснөөс авсан 4 дээжийн хүнд металлын шинжилгээ нь 6 төрлийн химийн хүнд металл болох никель, кадми, хар тугалга, цайр, хром болон зэс нь MNS5850:2019 стандартын элсэрхэг хөрсөнд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй тул бохирдолгүй болно.
- 2023 онд хийгдсэн хөрсний шинжилгээ нь хөрсний химийн бодисыг тодорхойлж, хүнд металл, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдсон байдлыг шалгаж үзэх зорилготойгоор холимог дээжийн судалгааг 28 элементийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.
- Шинжилгээний дүнгээс харахад МУ-ын MNS5850:2019 стандарт болон статистик тоо хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй нь тус төслийн талбайд хийгдэж байгаа засвар үйлчилгээ нь асгаралт шатах тослох материалын дүрэм журмыг сахин ажиллаж байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын ажлын чиглэлд 19 заалт бүхий ажлыг **80%** тай хэрэгжүүлэн ажиллалаа.

- Тухайн төслийн 2023 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөө нийт 13 бүлэг 98 заалттайгаар БОАЖЯ-ны ХБОБЗГ-аар 2023 оны 7-р сарын 20-ны өдөр батлагдсан.
- БОАЖС-ын 2021 оны 7-р сарын 9-ний өдрийн 01/3144 дугаар бүхий ай савын лавлагаатай.
- Дорноговь аймгийн БОАЖГ-ын 2023 оны 5-р сарын 24-ний өдрийн 253 дугаар бүхий Ус ашиглуулах дүгнэлттэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын 2023 оны 6-р сарын 29-ний өдрийн А/126 дугаар бүхий Ус ашиглуулах зөвшөөрөлтэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны 6-р сарын 29-ний өдрийн Ус ашиглуулах гэрээтэй.
- Галба-Өөш-Долоодын сав газрын 2023 оны 4-р сарын 03-ны өдрийн 2023/01 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэг тогтоох дүгнэлттэй.
- Дорноговь аймгийн Хатанбулаг сумын засаг даргын 2023 оны 10-р сарын 4-ний өдрийн А/172 дугаар бүхий хаягдал ус зайлуулах цэгийн зөвшөөрөлтэй.
- 2023 оны 1-р сарын 23-ны өдөр баталгаажсан LXLG-40 загварын 16м<sup>3</sup>/ц хэмжилтийн хязгаартай, 40 мм голчтой, 202000311 дугаартай, 047 дугаар бүхий лацтай тоолуурыг 2023 оны 1-р сарын 26-ны өдөр суурилуулсан.
- Төслийн хэмжээнд дагаж мөрдөх шаардлагатай 23 байгаль орчны журмын жагсаалтыг тодорхойлсон.
- Байгаль орчны хөндлөнгийн аудитыг “Мон газар консалтинг” ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд холбогдох тайлан, зөвлөмж ирээгүй байна.

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” ТӨСЛИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



- БОМТ-2023 нийт төсөв **84.9 сая.**
- Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг төслийн дотоод орчинд ажилчдын дунд зохион байгуулан ажиллалаа.

**Ерөнхий дүгнэлт:**

ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН АГАРУУТ БАГИЙН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ГААЛИЙН ХЯНАЛТЫН ТАЛБАЙ, АЖИЛЧДЫН ХОТХОН, АВТО БААЗ БАЙГУУЛАХ” төслийн 2023 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт **92.7%** байна.



## ХАВСРАЛТУУД



TAKHILT KHAIRKHAN TRANS  
LLC

### ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС ХХК

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,  
Их Монгол Улсын гудамж,  
Моннис Бьюдинг, 6-р давхар  
Утас: + (976) 7720-0990, 88109158  
Email: admin@tkt.mn

2023.05.08 № 23/159  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ д

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАРТ

### Хүсэлт гаргах нь

Манай компани Дорноговь аймгийн Хатанбулаг сум, Агаруут багийн нутаг дэвсгэр Хангийн боомтод тээвэрчдийг тав тухтай амрах зориулалтаар ажилчдын хотхон, авто бааз болон гаалийн хяналтын талбайн үйл ажиллагааг 2021 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байна.

Усны тухай хуулийн 28-р зүйл заасны дагуу “Ус ашиглуулах боломжит нөөцийн дүгнэлт” - ийг гаргуулах хүсэлтэй байгаа тул зохих журмын хүрээнд шийдвэрлэн бидний ажилд дэмжлэг үзүүлнэ үү.

Тухайн талбай нь 5000 м.кв нь барилга, байшин байгууламж 45000 м.кв нь нүүрс цагаалах хэсэг, 5000 м.кв нь зам талбайн зориулалттай зохион байгуулагдсан бөгөөд 2023 оны урдчилсан төлөвлөгөөгөөр 4250 м.кв нь зам талбайн тоосжилтыг дарах усалгаа хийх, кемпэд тээврийн жолооч нар түр байрлах, гаалийн хяналтын талбай, кемпийн байнгын үйл ажиллагааг хангаж ажиллах ажиллагсад нийлээд - 150-250 хүртэлх хүн байх хүчин чадалтай.

Иймд 2023 оны манай ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг гарган өгнө үү.

Дээрх дүгнэлтийг гаргахад шаардлагатай бичиг баримтуудын бүрдлийг хүргүүлэв.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ЛАЙ ЖЭНЬБАО



ДОРНОГОВЬ АЙМАГ  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,  
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103  
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26  
Цахим шуудан: Dgaboajg@do.mne.gov.mn  
Цахим хаяг: www.do.mine.gov.mn

2023.05.24 № 253  
танай 2023.05.23 -ны № 23/169 -т

“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЛАЙ ЖЭНЬ БАО ТАНАА

Танай ирүүлсэн 2023 оны Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын тайлан болон бусад ирүүлсэн материалыг үндэслэн 2023 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлээ.

Хавсралт .... хуудастай.

Хувийг: Аймгийн Татварын хэлтэс, Хатанбулаг сумын Засаг даргын тамгын газарт

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ОТГОНБАЯР



442303372



ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР 2023 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар-21

Сайншанд хот

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:  
“Тахилт хайрхан транс” ХХК-ийн захирал Лай жэнь бао, Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 15-р хороо, Их монгол улсын гудамж, Моннис Бьюлдинг, 6 давхар, Утас: 80215274, Улсын бүртгэлийн дугаар 9011730029, регистрийн дугаар 6284655

2. Төслийн нэр, байршил:

Дорноговь аймаг Хатанбулаг сумын нутагт байрлах Ханги тээврийн ажилчдын хотхон, автобааз, гаалийн хяналтын талбай

3. Төсөл хэрэгжүүлэгч: “Тахилт хайрхан транс” ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/: 4408006262

X	Y
109° 57' 18.17”	42° 42' 19.968”
109° 56' 50.706”	42° 42' 53.157”
109° 57' 15.651”	43° 43' 4.552”
109° 57' 43.107”	42° 42' 31.240”

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:

Хатанбулаг сумын нутагт байрлах Ханги тээврийн ажилчдын хотхон, автобааз, гаалийн хяналтын талбай

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:

2023 оны 01 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний хооронд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Нийт 150-250 хүний бүрэлдэхүүнтэй ажиллана.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

2023 онд 4250 м<sup>2</sup> зам талбайд тоосжилт дарах усалгаа хийх, кемпэд тээврийн жолооч нар түр байрлах, гаалийн хяналтын тайлбай, кемпийн байнгын үйл ажиллагааг хангаж ажиллана.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:

Тус сумын төвд өрөмдлөг гүний худаг байдаг ба усны чанар, ундарга сайтай тул энэ районы ахуй хэрэгцээний усны гол эх үүсвэр болдог.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:

Хаягдал бохир усыг хөрсөнд шингээн зайлуулдаг.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:

14. Онцгой нөхцөл:

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, баримт бичгийн дагуу усны зарцуулалтыг тооцох

Байгаль орчны сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны түр норм”-ын дагуу тооцоход

$250\text{хүн} \times 20\text{л/хон} \times 340\text{хон} = 1700,0\text{м}^3$  / ажиллах нийт хугацаанд-унд ахуйн усны хэрэгцээ  
 $4250\text{м}^2 \times 2\text{л/м}^2 \times 1\text{удаа/хон} \times 365\text{хон} = 3102,5\text{ м}^3$  зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус  
Нийт ашиглах усны хэмжээ:  $1700,0\text{м}^3 + 3102,5\text{м}^3 = 4802,5\text{м}^3$  ажиллах нийт хугацаанд

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ: “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 20.1.1-д заасны дагуу ажиллагсдын унд- ахуйд ашиглах  $1700,0\text{м}^3$  усыг төлбөрөөс чөлөөлнө.

Зам талбайн тоосжилт дарахад ашиглах  $3102,5\text{ м}^3$  газрын доорх усны төлбөрийн хэмжээг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Галба-Өөш Долоодын говийн сав газарт тогтоосон газрын доорхи усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор тогтоосон ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1-р хавсралтын 4-д заасан заасан усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг үндэслэн тооцож, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг “Төсвийн тухай” хуулийн 23.6.5-д заасны дагуу аймгийн Төрийн сангийн 060000-944 тоот дансанд төвлөрүүлэх;

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн ус ашигласны төлбөрийг тооцвол:

$1\text{м}^3$  усны нөөц ашигласны төлбөр:  $3996\text{төг/м}^3 \times 0,20 \times 0,25 = 199,8\text{ төг/м}^3$  байна.

- $3996\text{төг/м}^3$ - “Галба-Өөш Долоодын говийн сав газар”-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 20хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 4-д заасан хувь хэмжээ.
- 0.25- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу эрэл, хайгуулын өрөмдлөг хийх газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

$3102,5\text{м}^3 \times 199,8\text{ төг/м}^3 = 619879,0\text{ төг}$  /зургаан зуун арван есөн мянга найман зуун далан есөн төгрөг/

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:

18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Хатанбулаг сумын Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулах /“Усны тухай” хуулийн 28.6-р зүйл/
- Усны шинжилгээг хийлгэж дүнг ирүүлэх
- “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийг мөрдөн ажиллах /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаал/
- “Аж ахуйн нэгжийн экологийн паспорт” хөтлөх /Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Стандартчилал хэмжилзүйн хэлтэсээс авах/
- Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч ажиллах /Усны тухай хуулийн 31.2-р зүйл/

- Байгаль орчны менежментын төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх
- Ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Хатанбулаг сумын Төрийн сан банкны дансанд тушааж хуулбар хувийг ирүүлэх /Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжын тухай" хуулийн 21.1, 20-р зүйл, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 51-р тогтоол/
- Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс болох 50 000 төгрөгийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Төрийн сан банкны 100 060013001 дансанд тушаах /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-376 тоот тушаал/
- Зөвлөмжид заасан ажлын тайлан, Ус ашиглалтын мэдээ тайланг 12-р сарын 05-нд багтаан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН:



Ш. АМГАЛАНСАЙХАН

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Н. ОТГОНБАЯР

9028668. ЭТ /152. 0622030037

НЭХЭМЖЛЭХ №

Нэхэмжлэгч:  
Байгууллагын нэр: До.Б.ОАЖГазар

Хаяг: Орон нутгийн өмчийн 3-р байр

Төлөгч:  
Байгууллагын нэр: Дөхчигтэй  
ХАСРХАЧ БРАНС ХХК  
Хаяг: ХАГЧ 6 МЕЛ СТМ

Утас, факс: 70522663  
Э-шуудан:  
Банкны нэр: Төрийн сан банк  
Банкны дансны дугаар: 100060013001  
Регистрийн дугаар: 9028668

Гэрээний № \_\_\_\_\_  
Нэхэмжилсэн огноо: 2023.05.24  
Төлбөр хийх хугацаа: 2023.06.01

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1.	<u>Вүгчигтэй Төгсгөлийн үндэслэлгүй үндэслэлгүй үндэслэлгүй</u>	<u>1</u>	<u>50,000</u>	<u>50000</u>

Дүн  
НӨАТ  
Нийт дүн 50000

Мөнгөний дүн Дөхчигтэй Төгсгөл болно.  
(үсгээр)

(Тамга) Дарга: ..... / ..... Н.Отгонбаяр

(Тамга) Хүлээн авсан: ..... / ..... /

Нягтлан бодогч: Н.Дүүрэгтэй / Н.Дүүхүүхэн /



ДОРНОГОВЬ АЙМАГ  
ХАТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 4/406

Аман-Ус

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.11 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дүгээр тушаал, Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын "Ус ашиглуулах тухай" 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 253 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Ханги боомтод байрлах ажилчдын хотхон, автобааз, гаалийн хяналтын талбайд кемпийн байнгын үйл ажиллагаа явуулах XV-4408006262 тусгай зөвшөөрөл бүхий "Тахилт хайрхан транс" ХХК-ний унд ахуй, зам талбайн тоосжилт дарах ажилд зориулан 3 дугаар багийн нутаг дахь Ханги боомтод байрлах "Тахилт хайрхан транс" ХХК-ийн концессын замын дагуух гүний худгаас авах 4802.5м<sup>3</sup> ус авч ашиглахыг зөвшөөрсүгэй.

2.Ус ашиглагч "Тахилт хайрхан транс" ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулан холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөж хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ж.Шинэтуяа)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын тамгын газрын дарга (Т.Цэцэгсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЭРДЭНЭБОЛД

442302283

БАТЛАВ  
Хатанбулаг сумын Засаг дарга  
С.ЭРДЭНЭБОЛД  
2023 оны 06 сарын 29-ны өдөр

УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

БАТЛАВ  
"ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС"  
ХХК-ийн Захирал  
ЖЭНЬ БАО /  
110219023 6284655  
AMT02013

Дугаар...

Хатанбулаг сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу "Дорноговь аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар"-ны 2023 оны 04 дугаар сарын 07-ны өдрийн 09 тоот ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн

Ус ашиглуулагчийг төлөөлж Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Байгаль орчны мэргэжилтэн Жаргалсайхан овогтой Шинэтуяа, нөгөө талаас ус ашиглагч /Цаашид "Ус ашиглагч" гэх/-ийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Их Монгол улсын гудамж, Моннис бьулдинг, 6-р давхар "Тахилт хайрхан транс" ХХК, улсын бүртгэлийн дугаар 9011730029, регистрийн дугаар 6284655, байгаль орчны ахлах мэргэжилтэн Б.Лхагважаргал нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаагаар байгуулав

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 Ус ашиглах зориулалт Ариутгал халдваргүйтгэл болон хүн амын унд ахуйн хэрэгцээнд усны нөөцийг ашиглана.

2.2 Ашиглах усны хэмжээ

2.2.1 унд-ахуйд 1700,0 м3 /жил/

2.2.2 Зам талбайн тоосжилтыг дарахад ашиглах ус - 3102,5м3/жил

2.3 Усны чанар, найрлага: Гүний худгийн уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн шинжилгээний хариу болон дүгнэлтийг тухай бүрт нь Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ

2.4 Усны эх үүсвэр болон байршил: Гидрогеологийн хувьд ан цавын ус харьцангуй бага тархалттай боловч зэргэлдээх Хатанбулаг сумын районд хийгдсэн судалгаа, геофизикийн зарим судалгааны үр дүнгээс үзвэл рифейн тунамал хувирмал зузаалагт гидрокарбонат найрлагатай ан цавын ус ихтэй. Унд ахуйн хэрэглээний усыг Саглагар сүмийн худгаас ашигладаг

Худгийн координат

Барилга байгууламж

Мэдээлэл байхгүй

2.5 Хаягдал усны хэмжээ: Унд-ахуйн хэрэгцээний бохир усыг хөрсөнд шингээж хаядаг

Стандартын шаардлага: Хаягдал бохир усыг цэвэршүүлэн хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ цэвэршүүлсэн бохир усны ерөнхий шаардлага /MNS-4943 2011/-ыг ханган ажиллана.

Хаях цэгийн байршил:

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:

Жинлэгдэх бодис, кг.....

Органик бодис, кг.....

Эрдэс бодис, кг.....

Хүнд металл, кг.....

Аюултай бохирдуулах бодис, гр.....

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Унд-ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төлөвлөж ирүүлнэ.

2.9. Усны тоолуур:

Төрөл, нэр, дугаар:

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Дүгнэлт 09-д заасны дагуу нийт 3102.5 м<sup>3</sup> усны нөөцийн төлбөр 619879.0 төг /зургаан зуун арван есөн мянга найман зуун далан есөн төгрөг/

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

#### **Гурав. Талуудын эрх, үүрэг**

Гэрээ байгуулагч талууд Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

#### **Дөрөв. Бусад**

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, шинжилгээний үзүүлэлт, экологийн паспорт хөтлөх /MNS 4219-94/ Засгийн газрын тогтоол, төлбөр тооцох аргачлал нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний 2.3, 2.4, 2.6, 2.7, 2.8 дахь заалтуудад заагдсан чанар, найрлага, байршил, бохирдуулах бодисын хэмжээ, хаягдал ус хаях цэгийн байршил, ус хамгаалах арга хэмжээний талаарх мэдээллийг тусгайлан гаргаж Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

4.4. Ус ашиглуулагч нь 2023 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.5. Талуудын тохиролцоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.6. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

- 4.6.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;  
4.6.2 аль нэг тал татан буугдсан бол.  
4.7. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Ус ашиглуулагчийг төлөөлж:**

Хатанбулаг сумын Байгаль орчны  
мэргэжилтэн

..... / Д.Ж. Шинэтуяа/



Хаяг: Дорноговь аймаг, Хатанбулаг сум,  
ЗДТГазрын байр, 1 давхар 105 тоот  
Харилцах утас: 86586066

**Ус ашиглагчийг төлөөлж:**

"Тахилт хайрхан транс" ХХК-  
ний байгаль орчны ахлах  
мэргэжилтэн

..... / Б. Лхагважаргал/

Хаяг: Улаанбаатар хот  
Хан-Уул дүүрэг 15-р хороо  
Их монгол улсын гудамж,  
6-р давхар  
Харилцах утас: : 99076875





БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
**ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН  
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**

305 тоот, Соёмбо цогцолбор, 3 дугаар баг,  
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103  
Утас/факс: (976) 7052 3681,  
Цахим шуудан: Galba.usgz@gmail.com

2023.04.05 № 63  
танай 2023.01.18 -ны № 23/28 -т


“ТАХИЛТ ХАЙРХАН ТРАНС” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЛАЙ ЖЭНЬБАО ТАНАА

Хаягдал ус зайлуулах цэг тогтоох дүгнэлтийг  
хавсралтаар хүргүүллээ.

Хувийг: Хатанбулаг сумын Засаг даргын тамгын  
газарт.

